



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ


САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2026 оны 02-р сар | Дугаар 87

АГУУЛГА

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

2-3 Бодлогын нийтлэл



4-7 Зохицуулалтын мэдээ



8-9 Ярилцлага

10 Тогтвортой санхүүжилт



11 Компанийн засаглал, комплайнс



12-13 Финтек ба регтек



14-23 Судлаачийн индэр

24-25 Үнэт цаасыг зээлэх зээлдүүлэх үйлчилгээ гэж юу вэ?



26-27 Олон улсын зах зээлийн мэдээ



28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс



**ТАНЫ САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ**

Алгоритмаар шийдвэр гаргах

Algorithmic decision-making

Статистик загвар, өгөгдөл ашиглан шийдвэр гаргах үйл ажиллагаа. Энэ аргыг төлбөрийн заавар илгээх, зээлийн хүсэлтийг шийдвэрлэх зэрэг санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэх ба ихэвчлэн их хэмжээний өгөгдлийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг боловсруулах замаар ашигладаг.



Зээлийн мэдээллийн систем

Credit Information System

Хувь хүн болон байгууллага, аж ахуй нэгж үүргээ биелүүлээгүйгээс үүссэн өрийн мэдээллийг бүртгэх, цуглуулах зорилгоор зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн үүсгэсэн сан. Энэ системийг зээл олгох шийдвэр гаргахад ашигладаг.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ


**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙГ
ФАКТОРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДЭМЖИХ НЬ**


Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь худалдааны хийгээд хоорондоо харилцан хамааралтай сүлжээ байдлаар явагдаж буй үйл ажиллагааг санхүүжүүлэх, мөнгөний урсгалын менежментийг оновчтой болгохын тулд санхүүжилт хийх болон эрсдэлийг бууруулах арга, техникийг ашиглаж буй үйл ажиллагаа бөгөөд ихэвчлэн нээлттэй дансны нөхцөлийн дагуу хийгдэж байна.

Нээлттэй дансны арилжаа нь худалдагч ба худалдан авагч талуудын хооронд шууд хийгдэх, ямар нэг банкны бүтээгдэхүүн эсвэл баримтанд суурилсан худалдааны хэрэгслээр дэмжигдээгүй хэлцэл, гүйлгээ буюу нэхэмжлэлд суурилсан хэлцэл юм.

“Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт” (НСС) хэмээх ойлголт нь өнөөдөр улс хоорондын худалдаа болон бизнесийн салбаруудыг санхүүжүүлэх олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шийдлүүдийг хамрах болсон бөгөөд дэлхийн факторингийн зах зээл 3.6 их наяд ам.доллараар хэмжигдэж байгаа өнөө цаг үед европын зах зээл 60–65%, Азийн зах зээл 25–30%, Хойд Америкийн зах зээл 5–7%, Ойрхи дорнодын орнууд 3–5 орчим хувийг тус тус эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд нээлттэй дансны нөхцөлийн дагуу хийгдэх олон улсын худалдаа, арилжааны хэмжээ мэдэгдэхүйц өсч байна. Нийт дэлхийн худалдааны (экспортын) 80 гаруй хувь нь аль хэдийнээ нээлттэй дансны нөхцөлийн хүрээнд хийгдэж байна. Үүний үр дүнд санхүүгийн байгууллагууд ч гэсэн өөрсдийн харилцагч компаниудад бүрэн автоматчлагдсан, зардал хэмнэх, төлбөр төлөх шинэлэг шийдэлтэй, санхүүжилтийн хувилбаруудыг санал болгож байна.





Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид өнөөгийн хүлээгдэж буй мөнгөн төлбөрийн үүргийг гагцхүү банк, санхүүгийн зээлийн үйлчилгээгээр л санхүүжүүлж байгаа нь аж ахуйн нэгжүүдээс цаг хугацаа, эх үүсвэр олж бэлтгэх хийгээд хүүгийн зардал, барьцаа хөрөнгийн шаардлага зэрэг ихээхэн хүчин чармайлт шаардаж, бизнесийн орчин тэлэх суурь боломжийг хязгаарлаж байна.

Нөгөөтэйгүүр, факторингийн үйл ажиллагаа үзүүлснээс үүсэх шимтгэл, хүүгийн орлого нь нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд заасан нэмүү өртөг шингэсэн санхүүгийн үйлчилгээ учир тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ гүнзгийрэн хөгжихөд татварын таатай орчин дутмаг байна.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ гүнзгийрч, факторингийн үйлчилгээний ач холбогдол нэмэгдэхийн хэрээр олон улсын жишигт нийцсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

2025 оны жилийн эцэст үйлчилгээ эрхлэгчдийн тоо 64–д (арилжааны 4 банкыг оруулсан дүнгээр) хүрсэн хэдий ч 27 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй байх ба 33 ББСБ–ын факторингийн тооцооноос үүссэн авлага 107.4 тэрбум төгрөг байгаа нь шаардах эрхийг шилжүүлэхтэй холбоотой эдийн засгийн харилцаа төдийлөн зах зээлд үүргээ гүйцэтгэхгүй байна.

Монгол Улсын хувьд факторингийн зах зээлийг нийлүүлэлт талаас нь тооцоходоо төр болон томоохон аж ахуйн нэгжүүдийн худалдан авалттай уялдуулах боломжтой бөгөөд тухайлбал, 2025 онд 2,435 төрийн болон орон нутгийн өмчит компани 48.7 их наяд төгрөгийн төсөвт

өртөгтэй тендер зарлаж, 14,389 этгээд шалгарч, давхардсан тоогоор 17,805 гэрээ байгуулсан бол зөвхөн бараа материалын худалдан авалтад 582.2 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Үүний зэрэгцээ 2024 оны байдлаар улсын хэмжээнд 108,378 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байгаагийн 76,561 буюу 70.6 хувь нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч байх ба 2009–2024 оны хооронд 33 458 төсөлд 5,0 их наяд төгрөгийн хүсэлт ирснээс зээл хүсэгчийн 26.7 хувь, санхүүжилтийн 22 хувийг шийдвэрлэсэн буюу шаардлагатай санхүүжилтийн 78 хувь буюу 3.9 их наяд төгрөгийн эх үүсвэрийн дутагдалтай байна.

Өөрөөр хэлбэл, факторингийн үйл ажиллагаа нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг уламжлалт банк санхүүгийн зээлийн бүтээгдэхүүнээс ялгаатайгаар бодит худалдааны гүйлгээ, нэхэмжлэлд суурилан санхүүжилт олгодоогоороо онцлог тул банк, санхүүгийн байгууллагын уламжлалт зээлийн сувгийг орлох бус, харин эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн сегментэд чиглэсэн, санхүүгийн зах зээлийн бүтцийн төрөлжилтийг дэмжих, олон улсын хэмжээнд жижиг, дунд бизнесийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангах чухал санхүүгийн хэрэгсэлд тооцогдож байна.

Санхүүгийн зохицуулах хороо факторингийн үйл ажиллагааны хөгжлийг шинэ шатанд гаргах, жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн мөнгөн урсгалыг факторингийн үйл ажиллагаагаар дэмжих зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулаад байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарах хүлээлттэй байна:

1. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид барьцаа хөрөнгө шаардлагагүйгээр санхүүжилт авах боломж бүрдэнэ.
2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийг зээлээр бус факторингийн үйлчилгээгээр санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
3. Худалдааны эргэлтийг сайжруулснаар бизнесийн таатай орчинг бүрдүүлэн санхүүгийн зах зээлийг гүнзгийрүүлэн хөгжүүлж, эдийн засгийг тэлнэ.
4. Санхүүгийн үйлчилгээний шуурхай, үл тасалдах байдлыг хангах оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ) –ЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛЛО



Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын 2026 оны 02 дугаар сарын 11–13–ны өдрүүдэд зохион байгуулагдсан ээлжит чуулга уулзалтад 200 гаруй улс орны төлөөлөл, олон улсын байгууллагын ажиглагчид оролцож, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр голлох асуудлуудыг хэлэлцлээ.

Чуулга уулзалтаар Австри, Итали болон Сингапур Улсын харилцан үнэлгээний тайланг хэлэлцэн, баталсан бөгөөд харилцан үнэлгээг тавдугаар шатны шинэчлэгдсэн, эрсдэлд суурилсан аргачлалаар гүйцэтгэсэнээрээ онцлог байв. Тус шинэчлэгдсэн аргачлалын дагуу улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээний замын зураглалыг ФАТФ–ын чуулга уулзалтаар баталж, уг замын зураглалд тусгагдсан арга хэмжээг гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх шаардлагыг холбогдох улс орнуудад тавьж байна.

Мөн стратегийн хүрээнд цахим орчинд үйлдэгдэж буй залилангийн цар хүрээ нэмэгдэж байгаатай холбогдуулан холбогдох баримт бичгүүдийг баталж, энэ хүрээнд залилангаас урьдчилан сэргийлэх, хохирогчдын хөрөнгийг буцаан олгох, гэмт этгээдүүдийг хуулийн хариуцлагад татах чиглэлд инновацад суурилсан арга хэрэгслийг ашиглах шаардлагыг онцоллоо. Түүнчлэн виртуал хөрөнгийн хил дамнан шинж чанар, технологийн хурдацтай хөгжлийг харгалзан оффшор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид, мөн стэйблкоин болон өмчлөгчгүй хэтэвчтэй холбоотой шинээр үүсч буй эрсдэлийг бууруулахад чиглэсэн тайланг баталж, энэ чиглэлээрх хяналт, зохицуулалтыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

Энэ удаагийн чуулга уулзалтаар ФАТФ–ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусаж буйтай холбогдуулан ФАТФ–ын дэд Ерөнхийлөгчийн албан үүргийг гүйцэтгэж байгаа Их Британи Улсын Гэйлс Томсонг томилохоор шийдвэрлэв.

Мөн ФАТФ–ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр өндөржүүлсэн хяналтад орсон орны жагсаалт буюу “саарал” жагсаалтад Кувейт, Папуа Шинэ Гвиней зэрэг улсуудыг оруулахаар шийдвэрлэсэн бол мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй орны жагсаалт буюу “хар” жагсаалтад өөрчлөлт оруулаагүй байна.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ТУРШЛАГАА ХУВААЛЦЛАА



Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсын Төв банкнаас (Nepal Rastra Bank) “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд тулгарч буй өнөөгийн сорилт, тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын бага хурлыг тус улсын Катманду хотноо зохион байгууллаа.

Тус бага хуралд Монгол Улсаас Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны хянан шалгагч Б.Номинчулуун оролцож, Монгол Улсын ФАТФ–аас өгсөн үүрэг даалгаврыг 6 сарын дотор биелүүлж, саарал жагсаалтаас гарсан туршлага, МУТСТ тогтолцоо, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, зохицуулалтын орчны талаар илтгэл танилцуулж, санхүүгийн болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, виртуал хөрөнгийн

үйлчилгээ үзүүлэгчид болон иргэд олон нийтэд чиглэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар сайн туршлагыг хуваалцлаа.

Балба Улсыг санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–аас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (МУТС) стратегийн дутагдалтай улсуудын жагсаалт буюу саарал жагсаалтад 2025 оны 02 дугаар сарын 21–ний өдөр оруулж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн билээ. Үүнтэй холбоотойгоор Балба Улсаас МУТС чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн МУТС тогтолцоо, хяналт шалгалтыг бэхжүүлэх, олон улсын сайн туршлагыг судлах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор энэхүү хурлыг зохион байгуулсан юм. Тус бага хуралд Энэтхэг, Бангладеш, Шри Ланка болон Монгол Улсын зохицуулагч байгууллагын төлөөллүүд урилгаар оролцож, МУТС тогтолцооны өнөөгийн эрсдэл, хяналт шалгалтын арга зүй, хууль эрх зүйн орчны шинэчлэл, чадавхыг бэхжүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлээ.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧДЫН ЗАРДАЛ БУУРАХ НӨХЦӨЛ БҮРДЛЭЭ

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох замаар зээлийн зардлыг зах зээлийн зарчмаар бууруулах зорилгоор Улсын Их Хурлаас 2025 онд “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” 79 дүгээр тогтоолыг баталсан.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо дотоодын аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн оролцогчдын хөрөнгийн зах зээлд оролцох зардлын ачааллыг бууруулж, үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргаж, зохицуулалтын үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг бууруулж байна.

Тодруулбал, хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс тооцон авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 100 хувиар, арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс тооцон авдаг хөлсийг 50 хувиар, мөн үнэт цаасны арилжаа эрхлэх этгээдүүдийн шимтгэлийн орлогоос тооцон авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 50 хувиар тус тус буурууллаа.

Түүнчлэн үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс тооцон авах зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2027–2030 он хүртэлх хугацаанд түр чөлөөлөхөөр

шийдвэрлэсэн нь салбарын тогтвортой хөгжил, зах зээлийн идэвхжлийг дэмжих бодлогын чухал алхам боллоо.

Энэхүү шийдвэрийн хүрээнд үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болох арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, клирингийн болон бусад зохицуулалттай этгээдүүдийн шимтгэл, хураамж шат дараатайгаар буурч, зах зээлийн үйл ажиллагааны үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх боломж бодитоор нэмэгдэж байна.

Үүний үр дүнд хөрөнгийн зах зээлд оролцогчдын зардал буурч, дотоодын аж ахуйн нэгжүүд үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах боломж өргөжинө. Улмаар зах зээлийн өрсөлдөх чадвар бэхжиж, хөрөнгийн зах зээлийн хөгжил эрчимжин, бодит эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих суурь нөхцөл улам баталгаажих байна.

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС /ЛИЗИНГ/–ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДЭД МЭДЭГДЭХ НЬ

Улсын Их Хурлаас иргэдийн бодит орлогыг хамгаалах чиглэлээр мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, иргэдийг хэрэглээний зээлийн хэт өсөлт, их хэмжээний өрийн дарамт, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор зээлийн мэдээллийн санд нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төрийн холбогдох эрх бүхий байгууллагуудад даалгасан.

Тус бодлогын арга хэмжээний хүрээнд Монголбанк шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлд тооцох өр, орлогын харьцааг 45 хувиас хэтрүүлэхгүй байхаар, Санхүүгийн зохицуулах хороо банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа 55 хувиас хэтрүүлэхгүй байхаар тус тус шийдвэрлэсэн. Мөн зээлдэгчийн зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк нь хамтран ажиллаж, зохих арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж байна.

Иргэдийн санхүүгийн хамгааллыг бэхжүүлэх үүднээс, санхүүгийн түрээс /лизинг/–ийн үйл ажиллагаа эрхлэгч нь төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зохицуулалтад хамааралгүйгээр үйл ажиллагаа эрхэлдэг боловч Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2–т заасны дагуу Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээллийг тогтмол нийлүүлэх үүрэг хүлээдэг. Ингэснээр иргэдийн бодит орлогод нийцсэн үнэ бүхий бараа, бүтээгдэхүүнийг санал болгон, худалдан

борлуулах нь иргэдийн хэрэглээний зээлийн хэт өсөлт, учирч болзошгүй өрийн дарамт, цахим зээлийн давхардлаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Харин үүний эсрэгээр, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр “орлого нотлохгүй”, “өр, орлогын харьцааг харгалзахгүйгээр лизингээр бараа олгоно” зэрэг агуулгатай зар сурталчилгааг нийтэлж, иргэд болон өрхийн төлбөрийн чадварыг харгалзан үзэхгүйгээр үйлчилгээ үзүүлэх нь иргэдийг өрийн дарамтанд оруулах, улмаар санхүүгийн болон сэтгэл санааны хохирол бий болох, цаашлаад өрхийн бодит орлого, иргэдийн худалдан авах чадвар буурах замаар улсын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх бодит эрсдэл, сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй байна.

Иймд та бүхэн үйл ажиллагаа эрхлэхдээ хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, дээр дурдсан эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг төөрөгдүүлэхүйц зар сурталчилгаа явуулахгүй байх, санхүүгийн түрээсээр бараа, бүтээгдэхүүн борлуулахдаа худалдан авагчийн төлбөрийн чадварыг бодитойгоор үнэлж шийдвэр гаргах, зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг тухай бүр үнэн зөвөөр нийлүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй, зөвшөөрөлгүйгээр зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэхийг анхааруулж байна.

Жич: Хэрэв санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны 51–261275 дугаарын утсаар мэдэгдэх боломжтой.

АЗИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН 9 ДЭХ УДААГИЙН ХУРАЛ БОЛЛОО

Азийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагч байгууллагуудын 9 дэх удаагийн хурал Тайландын Хаант Улсын Бангкок хотноо амжилттай зохион байгуулагдлаа.

Тус хурлыг Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (АССУ) зохион байгуулж, Азийн 15 улсын зохицуулагч байгууллагын 50 гаруй төлөөлөгч оролцсон байна. Хурлаар хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулалтын орчныг бэхжүүлэх зорилгоор хоршоодын дээвэр байгууллагаар

дамжуулан хяналтын зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сайжруулах, мөн хоршоодын хөрөнгийг эрсдэлээс хамгаалах асуудлуудыг өргөн хүрээнд хэлэлцлээ.

Эдгээр асуудал нь гишүүддээ, тэр дундаа орон нутгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг илүү найдвартай, тогтвортой болгох, цаашдын өсөлт хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 оноос эхлэн Азийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын нийгэмлэг (ACCRA)–ийн дэд даргаар сонгогдон ажиллаж байна.

ДААТГАГЧИЙН БАТАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫН ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ

Монгол Улсад даатгагчийн баталгаа гаргах хууль, эрх зүйн орчин бүрдэж, уг тогтолцоо бодитоор хэрэгжиж эхлээд хоёр жил болж байна. Өнгөрсөн онд даатгалын компаниуд төрийн худалдан авах ажиллагаатай холбоотойгоор нийт 611.8 тэрбум төгрөгийн дүнтэй 1200 гаруй баталгаа гаргасан нь өмнөх оноос 27 дахин өссөн үзүүлэлт болж, даатгагчийн баталгааны эрэлт, хэрэгцээ зах зээлд хурдацтай нэмэгдэж буйг харуулж байна.

Одоогоор баталгааны нийт зах зээлийн 5 орчим хувийг эзэлж байгаа хэдий ч даатгагчийн баталгаа нь богино хугацаанд итгэлцэлд суурилсан, уян хатан, шударга санхүүгийн хэрэгсэл болон төлөвшиж, бизнесийн орчинд бодит нөлөө үзүүлж эхлээд байна.

Энэ нөхцөл байдалтай уялдуулж даатгагчийн баталгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг өргөжүүлэх зорилгоор “Даатгагчийн баталгаа – Итгэлцэл ба хөгжил” сэдэвт салбарын нэгдсэн хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хороо, Даатгагчийн баталгааны удирдах зөвлөл, Монголын даатгалын холбоо хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт УИХ–ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Санхүүгийн зохицуулах хорооны орон



тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун болон салбарын оролцогчид, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл өргөнөөр оролцлоо.

Хэлэлцүүлгийг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц хэлэхдээ, даатгагчийн баталгаа нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд 2022 онд хууль эрх зүйн зохицуулалт нь бүрдэж, 2023 оноос бодитоор хэрэгжиж эхэлсэн, онцлог ач холбогдол бүхий шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн болохыг дурдаад, энэхүү бүтээгдэхүүн нь нэг, хоёр даатгалын компанийн санаачилгаар бус, салбарын нийт оролцогч нэгдэн хамтарч удирдах зөвлөл байгуулан зах зээлд нэвтрүүлсэн нь салбарын хамтын ажиллагааны бодит жишээ болсныг онцлолоо.

Мөн тэрбээр даатгагчийн баталгаа нь уламжлалт банкны баталгаа, батлан даалтын зарим хэрэгцээг орлох шинэ боломжийг бий болгож, санхүүгийн зах зээлийн бүтэц, хүртээмжийг тэлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. 2024 онд 5 даатгалын компани нийт 22 тэрбум төгрөгийн баталгаа гаргасан бол 2025 онд 10 даатгалын компани тендерийн, гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн болон чанарын баталгааг хамарсан 611.8 тэрбум төгрөгийн баталгаа гаргасан нь уг бүтээгдэхүүний эрэлт богино хугацаанд эрчимтэй өссөнийг илтгэж байна.

Даатгагчийн баталгаа нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн үйлчилгээ илүү ойртож, бодит боломж болж байгааг онцлов. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо 2025 оны 12 дугаар сард даатгагчийн баталгаа гаргах дээд хэмжээг 3–4 дахин нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь зохицуулалтын уян хатан байдлыг хангах, зах зээлийн эрэлтийг дэмжих бодит алхам болж чадсан.

Нөгөөтэйгүүр даатгагчийн баталгаа нь даатгалын компаниудын хувьд эрсдэл дагуулсан санхүүгийн үйлчилгээ тул эрсдэлийг зохистой удирдах зорилгоор эрсдэлийн сан бүрдүүлэх, давхар даатгалын зохицуулалтыг өргөжүүлэх зэрэг бодлогын цогц шийдлүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр зохицуулалтын үр дүнд даатгагчийн баталгааны үйлчилгээ өмнөх оноос 27 дахин өссөн бөгөөд 2026–2027 онд зах зээл цаашид эрчимтэй тэлнэ гэсэн хүлээлттэй байгааг илэрхийллээ.

Мөн даатгагчийн баталгаа нь зөвхөн тендер, төрийн худалдан авах ажиллагаанд хязгаарлагдах бүтээгдэхүүн биш гэдгийг онцолж, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр, хувийн хэвшлийн худалдан авалт, ажил гүйцэтгэх гэрээнүүд зэрэг олон чиглэлд ашиглагдах боломжтой, цаашид илүү өргөн хүрээнд хөгжих санхүүгийн хэрэгсэл гэдгийг тодотгоод уг бүтээгдэхүүнээр дамжуулан аж ахуйн

нэгжүүдийг бусад төрлийн даатгалд хамруулах, эрсдэлээ хамгаалах ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар даатгалын зах зээлийг бүхэлд нь тэлэх стратегийн ач холбогдолтой хөшүүрэг гэж Санхүүгийн зохицуулах хороо үзэж байгааг онцолсон юм.

Хэлэлцүүлгийн төгсгөлд оролцогчид даатгагчийн баталгааны өнөөгийн байдал, зах зээлд тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн боломж, чиг хандлагын талаар нээлттэй, бодит шийдэлд чиглэсэн санал солилцож, салбарын оролцогчид болон харилцагчдад уг бүтээгдэхүүний ач холбогдлыг тодорхой таниулах, нэгдсэн ойлголт бүрдүүлэх, итгэлцэл, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой болсныг онцлон дүгнэв.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Монгол Улсад Санхүүгийн зохицуулагч байгууллага үүсэж, хөгжсөний 20 жилийн ойн хүрээнд Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран “Санхүүгийн зах зээл: сорилт, инновац, тогтвортой хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааныг 2026 оны 4 дүгээр сарын 24–ний өдөр зохион байгуулах гэж байна.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



UFE

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 20 ЖИЛ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ

БҮТЭЭЛИЙН УРАЛДААН

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, онол, практикийн ач холбогдол бүхий судалгааны шинэ бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, оюутны болон судлаачийн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг дэмжихэд оршино.

ОРОЛЦОГЧДЫН АНГИЛАЛ

ШАГНАЛЫН САН

СУДЛААЧ:
Магистр, докторын түвшний суралцагчид, эрдэмтэд, салбарын мэргэжилтнүүд

I Өргөмжлөл 5,000,000₮	II Өргөмжлөл 4,000,000₮	III Өргөмжлөл 3,000,000₮
---------------------------	----------------------------	-----------------------------

ОЮУТАН:
Их, дээд сургуулийн бакалаврын түвшний оюутнууд

I Өргөмжлөл 3,000,000₮	II Өргөмжлөл 2,500,000₮	III Өргөмжлөл 2,000,000₮
---------------------------	----------------------------	-----------------------------

ХУГАЦАА

<p>2026.04.10</p> <p>Судалгааны бүтээлийг research.ufe.mn цахим хуудсаар хүлээн авна.</p>	<p>2026.04.17</p> <p>Шалгарсан оролцогчдод и-мэйлээр мэдээлэл хүргэнэ.</p>	<p>2026.04.23</p> <p>Шалгарсан бүтээлийг research.ufe.mn цахим хуудсаар хүлээн авна.</p>	<p>2026.04.24</p> <p>Нэгдсэн хуралдаан зохион байгуулагдана.</p>
--	---	---	---

УДИРДАМЖ 



ХОЛБОО БАРИХ:

Санхүүгийн зохицуулах хороо
www.frc.mn (976) 51-261106

Санхүү эдийн засгийн их сургууль
www.ufe.edu.mn (976) 8800-0094

ЯРИЛЦЛАГА

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ: ЖОЛООЧ ТАНЫ ЭРХ БА ҮҮРЭГ

Иргэд жолоочийн даатгал болон тээврийн хэрэгслийн даатгалыг андуурдаг тохиолдлууд их байдаг. Мөн даатгалын тохиолдол буюу осол гарсан үед ямар арга хэмжээ авах, хохирлоо хэрхэн нэхэмжлэх, хаана, хэнд хандахаа мэдэхгүй цаг алдсанаар нөхөн төлбөр авах боломжоо алдах, даатгалын компанитай маргаан үүсэх гэх мэт асуудлууд тулгардаг. Энэ асуудлаар Даатгалын газрын дарга З.Батболдтой ярилцлаа.

Юуны өмнө та жолоочийн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал хоёрын ялгааг тайлбарлаж өгнө үү?

Жолооч нь хариуцлагын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал гэсэн 2 өөр төрлийн даатгалд хамрагдаж байгаа. Хамгийн энгийнээр хэлбэл, жолоочийн хариуцлагын даатгал гэдэг нь таны буруугаас үүдэн осол гарсан бол таны бусдад учруулсан эд хөрөнгө, эрүүл мэндийн хохирлыг нөхөн төлөхөд зориулагдсан даатгал юм. Харин тээврийн хэрэгслийн даатгал бол таны өөрийн машины эвдрэл, гэмтлийг нөхөхөд зориулагдсан даатгалын бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл жолоочийн хариуцлагын даатгал нь таны бусдад учруулсан хохирлыг барагдуулах бол тээврийн хэрэгслийн даатгал таны машиныг хамгаална гэсэн үг юм.

Замын хөдөлгөөнд оролцож буй жолооч бүр даатгалд хамрагдах ёстой юу?

Жолооч бүр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хуулийн дагуу заавал хамрагдах үүрэгтэй. Энэ нь жолоочийн бусдын өмнө хүлээх хариуцлага бөгөөд зам тээврийн ослын улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх санхүүгийн баталгаа болдог. Иймд энэ даатгал нь зөвхөн хувь хүний асуудал биш, олон нийтийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт юм.

Харин тээврийн хэрэгслийн даатгал нь сайн дурын даатгал бөгөөд жолооч өөрийн автомашиныг хамгаалах зорилготой тул заавал даатгуулах үүрэгтэй биш. Жишээлбэл, Та замын хөдөлгөөнд оролцох үедээ өөрийн буруутай үйлдлээс болж мөргөлдсөн, тээврийн хэрэгсэлд гал гарсан, хулгайд өртсөн бол тээврийн хэрэгслийн

даатгал таны машинд учирсан хохирлыг нөхөн төлнө гэсэн үг юм. Гэхдээ даатгуулагч ямар эрсдэлүүдийг даатгалаар хамгаалуулж байгаа вэ гэдгээ анхаарах, даатгалын гэрээтэйгээ сайн танилцах, даатгуулагчийн хувьд эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх ёстой.

Жолооч даатгуулагчийн хувьд ямар эрх, үүрэгтэй вэ?

Жолооч даатгалын нөхцөлөө даатгагчаар ойлгомжтой тайлбарлуулах, даатгалын тохиолдол үүссэн бол нөхөн төлбөр авах, хохирлын үнэлгээтэй санал нийлэхгүй бол дахин үнэлүүлэх, даатгагчийн шийдвэртэй санал нийцэхгүй бол Хороонд гомдол гаргах эрхтэй. Зохицуулах байгууллагын зүгээс иргэдийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, хууль журмын хүрээнд шийдвэрлэдэг.

Харин даатгуулагчийн хувьд хүлээх үүрэг нь даатгалын зүйл буюу машины талаарх мэдээллийг даатгагчид үнэн зөв өгөх, шударга байх, даатгалын тохиолдол гарсан бол даатгалын компанидаа шуурхай мэдэгдэх, нөхөн төлбөр нэхэмжлэхэд шаардлагатай баримтыг бүрдүүлэх үүрэгтэй.

Эдгээр эрх, үүргээ биелүүлэхийн тулд даатгалын тохиолдол үүссэн үед даатгалын компанид яаж мэдэгдэх, нөхөн төлбөр нэхэмжлэхэд бүрдүүлэх материал, шаардлага зэргийг гэрээ байгуулахаас өмнө маш сайн асууж тодруулах хэрэгтэй. Мөн даатгагч үйлчлүүлэгчдээ тайлбарлах, мэдлэг, мэдээлэл өгөх үүрэгтэй.

Жолоочийн хариуцлагын даатгал хуулиар заавал даатгуулах зохицуулалттай тул даатгалд хамрагдалт өндөр байдаг. Тэгвэл тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдалт хэр байгаа вэ?

Яг тийм, жолоочийн хариуцлагын даатгалын тухайд 2025 онд 875.3 мянган даатгалын гэрээ байгуулагдаж, даатгалын компаниуд 40.4 мянган нэхэмжлэл хүлээн авч, үүнээс 92.8 хувьд нь нөхөн төлбөр олгосон. Харин тээврийн хэрэгслийн даатгалын 140.7 мянган гэрээ байгуулагдаж, 27.4 мянган нэхэмжлэлийн 86 хувьд нь 47.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Өөрөөр хэлбэл тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдалт жолоочийн хариуцлагын даатгалаас 6 дахин бага байгаа

нь жолооч нар маань өөрийн эд хөрөнгө буюу машинаа учирч болох эрсдэлээс хамгаалаагүй байна гэж хэлэхээр байна. Монгол Улсад 1 сая гаруй автотээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 80 гаруй хувь нь даатгалгүй байна.

Харин технологийн дэвшлийн үр дүнд цахим даатгал хөгжиж байгаа нь даатгуулагч даатгалын бүтээгдэхүүн худалдан авах, даатгалын компани нөхөн төлбөрийг илүү хялбар, хурдан шуурхай олгох боломжийг бүрдүүлж байгааг дашрамд дурдмаар байна.

Ярилцлагын төгсгөлд жолооч нарт хандаж зөвлөгөө өгнө үү?

Нэгдүгээрт, албан журмын даатгалд заавал хамрагдах нь таны хуульд заасан үүрэг юм. Хоёрдугаарт, өөрийн автомашинаа учирч болзошгүй эрсдэлээс хамгаалахын тулд тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдахыг зөвлөж байна. Гэхдээ даатгалын бүтээгдэхүүн бүр тодорхой нөхцөлтэй байдаг. Ямар эрсдэлээс хамгаалж байгаа,

хамгаалахгүй байгаа, ямар нөхцөлд нөхөн төлбөр олгогдохгүй байх зэргийг гэрээнд тусгасан байдаг. Даатгуулагч гэрээг бүрэн уншаагүй, тайлбар асуугаагүйгээс “би мэдээгүй” гэсэн нөхцөл байдал үүсдэг. Гэтэл та гарын үсэг зурсан бол тухайн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогддог. Иймээс гэрээтэйгээ танилцаад өөрт тохирсон бүтээгдэхүүнийг худалдаж авах мөн гэрээний нөхцөлтэй санал нийлэхгүй байх, даатгагч хууль, журам зөрчсөн байвал Хороонд мэдэгдэх, гомдол гаргах эрхтэй гэдгийг хэлмээр байна. Гуравдугаарт, осол, хохирол тохиолдсон үед тайван байж, даатгагчийн зөвлөгөө, даатгалын гэрээнд заасны дагуу ажиллах нь таны эрх, ашгийг хамгаална.

Даатгал бол эрсдэлийг хамтдаа үүрэх тогтолцоо юм. Үүнд жолооч бүр хариуцлагатай оролцоноор замын хөдөлгөөний соёл, санхүүгийн хамгаалалт илүү баталгаатай болно.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН САНХҮҮЖИЛТИЙН УРСГАЛЫГ ХЭРХЭН ХЭМЖИХ ВЭ?

Ногоон санхүүгийн урсгалыг хянах доороос дээш (bottom-up) чиглэсэн аргачлалын хэсгээс

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол зэрэг дэлхий нийтийн тулгамдсан сорилтууд нь улс орнуудын хөгжлийн бодлогоос гадна санхүүгийн системд бодит өөрчлөлтийг авчирч байна. Энэ нь байгаль орчинд эерэг нөлөө бүхий төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашлаад ногоон санхүүжилтийн цар хүрээг тэлэх бодлогын тэргүүлэх зорилтуудын нэг болоод байна. Гэсэн хэдий ч бодит ногоон санхүүжилтийн хэмжээг тооцоолох, мөн зах зээлийн одоогийн нийлүүлэлт шаардлагатай түвшинд хүрч байгаа эсэхийг үнэлэх нь одоогоор амаргүй хэвээр байна. Учир нь “ногоон” ангиллын нэгдсэн тодорхойлолт дутмаг, хэмжилтийн аргачлалууд харилцан адилгүй, түүнчлэн өгөгдлийн хүртээмж, чанар хангалтгүй байгаа нь нэгдмэл, харьцуулах боломжтой үнэлгээ хийхэд томоохон саад болж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд ногоон санхүүжилтийг илүү нарийвчлалтай хэмжих аргачлалыг боловсронгуй болгох чиглэлд тодорхой ахиц гарч Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК) нь G20-ийн Ногоон Санхүүгийн Судалгааны ажлын хэсгийн хүрээнд ногоон санхүүгийн урсгалыг “доороос дээш” (bottom-up)

зарчмаар үнэлэх аргачлалыг боловсруулж, улс орнуудад санал болгосон.

Энэхүү аргачлал нь макро түвшний ерөнхий тооцооллоос илүүтэйгээр бодит төсөл, санхүүгийн гүйлгээнд тулгуурлан ногоон санхүүжилтийн хэмжээг тодорхойлохыг зорилготой. Аргачлал нь дараах гурван үе шаттай:

1. Төслийн түвшинд тухайн хөрөнгө оруулалтын зориулалт, эдийн засгийн бодит үйл ажиллагаанд үндэслэн байгаль орчинд ээлтэй “ногоон” эсэхийг тодорхойлж, хувь хэмжээг тооцоолно. Өөрөөр хэлбэл, зээл болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэдэн хувь нь байгаль орчинд эерэг нөлөөтэй үйл ажиллагааг дэмжиж байгааг тодорхойлно;
2. Эдгээр төслийн түвшний мэдээллийг салбар болон улсын түвшинд нэгтгэнэ. Ингэснээр тухайн улсын санхүүгийн системд ногоон санхүүжилтийн эзлэх хэмжээ, бүтэц, чиглэлийг тодорхойлох боломжтой;
3. Тооцсон үр дүнг шаардлагатай хөрөнгө оруулалтын эрэлттэй харьцуулна. Энэхүү үе шат нь бодлогын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд санхүүжилтийн “зөрүү” хаана, ямар салбарт, ямар хэрэгслээр үүсэж байгааг тодорхойлох үндэс болдог.

Зураг. Ногоон санхүүжилтийн урсгалыг хэмжих үе шатууд



Эх сурвалж: Green Finance: A Bottom-up Approach to Track Existing Flows

Энэхүү аргачлал нь санхүүжилтийн урсгалыг бодитой хэмжих боломжийг олгодог ч хэрэгжүүлэхэд хэд хэдэн сорилттой тулгардаг.

Хэрэгжилтийн явц дахь гол сорилтууд:

1. “Ногоон” тодорхойлолт

Ногоон санхүүжилтийг хэмжихэд хамгийн түрүүнд тулгардаг асуудал бол тухайн санхүүжилтийг “ногоон” хэмээх ангилалд ямар шалгуураар ангилах вэ гэдэг юм. Үүнийг тодорхойлохдоо мэдээллийн гурван үндсэн түвшинд тулгуурладаг.

Төслийн түвшний өгөгдөл: Хамгийн оновчтой арга нь санхүүжилтийн зориулалт, ашиглалт (use of proceeds)–ын ангиллыг ашиглан тухайн төслийн бодит үйл ажиллагааг шинжлэх явдал юм. Ингэснээр зээл, хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь байгаль орчинд эерэг нөлөөтэй үйл ажиллагаанд чиглэж байгааг тогтоох боломжтой. Гэвч практикт энэхүү ангилал хангалттай нарийвчлалтай бүртгэгдээгүй байх нь элбэг тохиолддог. Жишээлбэл, “төсөл санхүүжилт” гэж тэмдэглэдэг боловч “сэргээгдэх эрчим хүч” эсхүл “эрчим хүчний хэмнэлт” гэх мэт тодорхой зориулалт заагаагүй байх тохиолдол бий. Ийм нөхцөлд тухайн санхүүжилтийг ногоон эсэхийг үнэлэхэд мэдээллийн хоосон орон зай үүсдэг.

Салбарын түвшний өгөгдөл: Хэрэв төслийн зориулалтын мэдээлэл хангалтгүй бол төслийг хэрэгжүүлэгч компанийн салбарын ангиллыг ашиглан ногоон хувь хэмжээг ойролцоолон тодорхойлох боломжтой. Тухайлбал, барилгын салбар дахь баталгаажсан эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, орон сууцны эзлэх хувийг ашиглан тухайн салбарын “ногоон” бүрэлдэхүүнийг тооцоолох боломжтой. Гэвч салбарын ангиллын стандартууд мэдээллийн сан бүрд өөр өөр байдаг тул олон эх сурвалжийн өгөгдлийг хооронд нь уялдуулахад хүндрэл гардаг. Энэ нь тооцооллын нарийвчлалд нөлөөлдөг.

Компанийн түвшний өгөгдөл: Компанийн нийт орлогод эзлэх ногоон үйл ажиллагаанаас олсон орлогын хувь хэмжээ ашиглах нь илүү нарийвчилсан үнэлгээ хийх боломж олгодог. Гэвч ийм төрлийн мэдээлэл ихэвчлэн томоохон, ил тод тайлагнал хийдэг компаниудад л нэгдсэн стандартын дагуу бүртгэгдсэн байдаг. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд ийм мэдээлэл харьцангуй хомс байна.

2. Өгөгдлийг нэгтгэх

Ногоон санхүүгийн урсгалыг бодитой үнэлэхийн тулд төсөл, компани болон санхүүжүүлэгчийн мэдээллийг хооронд нь холбох шаардлагатай болдог. Гэвч энэ шатанд дараах бэрхшээлүүд тулгарна.

Зээлдэгчийн байршил: Төслийн бодит хэрэгжилтийн байршил ихэнхдээ стандартчилсан хэлбэрээр бүртгэгдээгүй байдаг. Иймээс төслийг хэрэгжүүлэгч компанийн бүртгэлтэй байршлыг ашиглах тохиолдол түгээмэл хэдий ч олон улсын үйл ажиллагаатай компанийн хувьд бүртгэлийн хаяг нь бодит хөрөнгө оруулалт хийгдсэн улсыг илэрхийлэхгүй байх боломжтой.

Санхүүжүүлэгчийн байршил: Өгөгдлийг санхүүгийн байгууллагаар нь нэгтгэх тохиолдолд тухайн төсөлд аль байгууллага хэдий хэмжээний санхүүжилт олгосон, мөн төслийн бодит байршилтай холбогдох мэдээлэл хязгаарлагдмал байх нь бий. Энэ нь дүн шинжилгээний гүнзгийрлийг хязгаарладаг.

Өгөгдлийн санг уялдуулах: Төслийн байршил, төслийг хэрэгжүүлэгч компани, санхүүжүүлэгч (банк, бонд гаргагч, хөрөнгө оруулагч)–ийн мэдээллийг хооронд нь холбохын тулд нэгдсэн танигч (төслийн бүртгэлийн дугаар, компанийн нэр, байгууллагын регистр гэх мэт) шаардлагатай. Гэвч мэдээллийн сангууд өөр өөр хувьсагч ашигладаг тул өгөгдлийг автоматаар нэгтгэхэд хүндрэл үүсдэг.

3. Эрэлт болон нийлүүлэлтийг харьцуулах

Нийлүүлэлт: Дээр дурдсан тодорхойлолт болон өгөгдлийн хязгаарлалтуудаас шалтгаалан ногоон санхүүжилтийн нийлүүлэлтийн тооцоо тодорхой хэмжээнд урьдчилсан таамаглалд тулгуурлах шаардлагатай болдог.

Эрэлт: Одоогийн бодлогын зорилтуудыг улс орон бүрийн салбарын түвшинд задалж, Парисын хэлэлцээр ба Нэгдсэн Үндэсний Байгууллагаас дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох шаардлагатай. Ингэхдээ санхүүгийн хэрэгсэл тус бүрээр (жишээлбэл, зээл, бонд, хувьцаат хөрөнгө оруулалт гэх мэт) хэрэгцээг нарийвчлан тооцоолсноор илүү бодитой, дэлгэрэнгүй шинжилгээ хийх боломж бүрдэнэ.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙНА ВЭ?

Сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ойлголт нь зөвхөн “хурал дээр санал өгөх” – өөр хязгаарлагдахаа больж, ил тод байдал, мэдээллийн чанар, цөөнхийн эрх ашиг, цахим оролцоо зэрэг бодит хэрэгжилтийн хэлбэрүүдээр тэлж байна.

Энэхүү өөрчлөлт нь хөрөнгө оруулагчдын эрхийг илүү бодитойгоор хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа ч нөгөө талдаа компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), гүйцэтгэх удирдлага, дотоод хяналт, нийцэл болон эрсдэлийн удирдлагын тогтолцоонд илүү өндөр шаардлага тавьж эхэллээ.

Энэ чиг хандлагыг дараах үндсэн хүчин зүйлс тодорхойлж байна. Үүнд:

- ◆ институциональ хөрөнгө оруулагчдын (тэтгэврийн сан, даатгал, хөрөнгө удирдлагын компани зэрэг) нөлөө өсөх;
- ◆ саналын эрхийн ялгаатай хувьцаа нэмэгдэх;
- ◆ холбогдох этгээдийн хэлцэлтэй холбоотой хамгаалалт чангарах;

хувьцаа эзэмшигчдийн хурлын цахим оролцоо тэлэх явдал юм.

Институциональ хөрөнгө оруулагчдын нөлөө ба “хариуцлагатай оролцоо”

Институциональ хөрөнгө оруулагчдын саналын жин өсөхийн хэрээр тэд зөвхөн ашиг хүртэгч бус, харин хөрөнгө оруулсан компанийн засаглалд **хариуцлагатай, идэвхтэй оролцогч** байх шаардлага улам нэмэгдэж байна. Үүнийг олон улсад *stewardship* буюу **хариуцлагатай оролцоо** гэж нэрлэдэг.

Энэ хүрээнд дараах шаардлагууд түгээмэл болжээ:

- ◆ Санал өгөх бодлогоо олон нийтэд ил болгох;
- ◆ Санал өгсөн асуудлаа тайлагнах;
- ◆ Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах дотоод бодлоготой байх;

Компанийн удирдлагатай тогтмол харилцаж, уг харилцааг тайлагнах, нотлох боломжтой байдлаар хэрэгжүүлэх.

Жишээлбэл, санал өгөх бодлогоо ил болгосон институциональ хөрөнгө оруулагчид 2014 онд 50 орчим хувь байсан бол 2024 онд 90 хувьд хүрчээ. Ашиг сонирхлын



зөрчлийн бодлоготой байх үзүүлэлт мөн хугацаанд бараг бүрэн хэрэгжилттэй болж өссөн байна.

Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлын асуудлаар зөвлөмж боловсруулдаг зөвлөх байгууллагууд (*proxy advisory firm*)–ын нөлөө нэмэгдэж, мэдээллийн чанар, ашиг сонирхлын зөрчлийн удирдлагад шинэ шаардлага бий болгож байна.

“Нэг хувьцаа – нэг санал” зарчим уян хатан болж байна

Капитал татах боломжийг нэмэгдүүлэх, богино хугацааны үр ашигт хэт төвлөрөхийг сааруулах зорилгоор зарим зах зээлд саналын эрхийн ялгаатай хувьцаа нэмэгдэж байна. Үүнийг *multiple voting rights* буюу ялгаатай саналын эрх (нэг хувьцаанд хэд хэдэн санал ногдуулах) гэж нэрлэдэг.

Гэвч ийм үед цөөнхийн эрх ашгийг хамгаалах хамгаалалтын багц зайлшгүй дагалдах ёстой. Үүнд:

- ◆ мэдээллийн ил тод байдал;
- ◆ эрх дордуулсан тохиолдолд тухайн ангиллын хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлийг авах;
- ◆ саналын эрхийн дээд хязгаар (*cap*);

тодорхой хугацааны дараа тусгай эрх автоматаар хүчингүй болох нөхцөл (*sunset*) зэрэг орно.

2024 оны байдлаар саналын эрхийн ялгаатай хувьцааг зөвшөөрсөн улс орнуудын эзлэх хувь 60–д хүрсэн бол ийм бүтцийг бүрэн хориглосон зах зээлийн тоо харьцангуй буурчээ. Зарим зах зээлд урт хугацаанд хувьцаа эзэмшсэн этгээдэд нэмэлт саналын эрх олгох хэлбэр (*loyalty shares*) ч ашиглагдаж байна.

Гол зорилго нь хөрөнгө татах уян хатан байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зах зээлийн шударга байдал, цөөнхийн эрх ашгийг алдагдуулахгүй тэнцвэрийг хадгалах явдал юм.

Холбогдох этгээдийн хэлцэл ба “давхар хамгаалалт”

Өмчлөлийн төвлөрөл нэмэгдэхийн хэрээр цөөнхийн эрх ашгийг хамгаалах гол механизм нь компани нь ашиг сонирхлын зөрчил үүсэх боломжтой этгээдтэй хийж буй хэлцэл буюу холбогдох этгээдийн хэлцэл (*Related Party Transactions – RPT*) болж байна.

Олон улс холбогдох этгээдийн хэлцлээс үүсэх эрсдэлийг бууруулахын тулд дараах **давхарласан хамгаалалтыг** түгээмэл хэрэглэж эхэлжээ. Үүнд:

- ◆ томоохон хэлцэлд ТУЗ–ийн зөвшөөрөл шаардах;
- ◆ хэлцлийг шуурхай, бүрэн мэдээлэх;
- ◆ сонирхолтой этгээд санал өгөхөөс түдгэлзэх;
- ◆ ТУЗ–ийн хараат бус гишүүд, Аудитын хорооны хяналт;

шаардлагатай тохиолдолд гаднын мэргэжлийн дүгнэлт авах гэх мэт зохицуулалт нь нэг шалгуураар хэмжигдэх бус, **олон давхар хамгаалалттай цогц шийдэл** болж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын цахим оролцоо

Хувьцаа эзэмшигчдийн хурал дан цахим болон танхим–цахим хосолсон хэлбэрт шилжих хандлага эрчимжиж байна. Энэ нь оролцоог нэмэгдүүлэх эерэг талтай боловч дараах зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Үүнд:

- ◆ асуулт асуух, санал гаргах, санал өгөх тэгш боломж;
- ◆ мэдээлэлд ижил хугацаанд нэвтрэх нөхцөл;
- ◆ мэдээллийн аюулгүй байдал;

техникийн саатлын үед хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөө (*fallback*).


2024 оны байдлаар дан цахим хурлыг 85 хувь, хосолсон хурлыг 94 хувь нь зөвшөөрсөн нь энэ чиг хандлага цаашид тогтворжихыг харуулж байна.

Эх сурвалж: www.oecd.org

ФИНТЕК БА РЕГТЕК

Топ 10 Мобайл Хэтэвч Нийлүүлэгчид

Мобайл хэтэвч нь илүү уян хатан, биометрик баталгаажуулалттай болж буй бөгөөд нэг аппликейшнд олон төрлийн үйлчилгээг нэгтгэх байдлаар хурдацтай хөгжиж байна. Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд шингэж, зөвхөн мөнгө шилжүүлэх төдийгүй санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг нэг дороос хялбар авах боломжийг олгож финтек салбарт томоохон хувьсгал авчирч байна.



1. APPLE PAY



Apple Pay нь хэрэглэгчийн худалдан авалтын мэдээллийг хянах, гуравдагч талд дамжуулахгүй байх бодлогыг баримталдаг. Аюулгүй байдлын хувьд нүүр танилт болон хурууны хээгээр баталгаажуулалт хийж, төхөөрөмжийн түвшний шифрлэлтийг ашиглан гүйлгээг хамгаалдаг. Сүүлийн жилүүдэд /Apple Pay Later/ дараа төлөх үйлчилгээ, мөн өндөр хүүтэй хадгаламжийн данстай интеграцчилсан шийдлийг нэвтрүүлсэн. Иймээс стандарт, найдвартай ажиллагаа болон олон улсын зах зээл дэх өргөн хэрэглээний цар хүрээгээрээ жагсаалтын №1 байрт эрэмбэлэгдэж байна.

2. WECHAT PAY



WeChat Pay нь өөрийн хэрэглээ өндөр аппликейшнтэй нэгтгэгдсэнээрээ онцлог бөгөөд хэрэглэгчид мессеж бичих, такси дуудах, эмчийн цаг захиалах зэрэг олон төрлийн үйлчилгээг нэг платформоос авах боломжтой юм. 1.3 тэрбум гаруй хэрэглэгчтэй бөгөөд өдөр тутмын амьдралд хялбар хэрэглэгддэг төлбөрийн шийдэл болж чадсан.

3. GOOGLE PAY



Google Pay нь Андроид экосистемтэй холбогдсон тул андроид төхөөрөмжүүд дээр жигд, саадгүй ажилладаг. Тус үйлчилгээ нь хэрэглэгчийн зардлыг автоматаар ангилж, и-мэйлд ирсэн баримт, төлбөрийн мэдээллийг татан нэгтгэх зэрэг ухаалаг функцээр ажилладаг. Мөн Энэтхэг зэрэг зах зээлд UPI интеграцлалтайгаар QR код ашиглан банк хооронд шууд, хурдан гүйлгээ хийх боломжийг бүрдүүлдэг.

4. AMAZON PAY



Amazon Pay нь хэрэглэгчийн Амазоны түгээмэл дансны мэдээллийг ашиглан гуравдагч вэбсайт, онлайн дэлгүүрүүд дээр хурдан бөгөөд хялбар төлбөр хийх боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр хэрэглэгч төлбөр бүр дээр картын мэдээллээ дахин оруулах шаардлагагүй бөгөөд худалдан авалтын үйл явц илүү шуурхай болдог. Мөн Amazon Alexa-тай интеграцчилснаар дуу хоолойгоор төлбөр баталгаажуулах боломжтой.

5. SAMSUNG PAY



Samsung Pay нь Samsung Knox аюулгүй байдлын системээр хамгаалагдсан тул хэрэглэгчийн гүйлгээ, картын мэдээллийг өндөр түвшний шифрлэл, хамгаалалтаар баталгаажуулдаг. Энэхүү үйлчилгээ нь Самсунг хэтэвчтэй нэгтгэгдсэн бөгөөд хэрэглэгч дижитал түлхүүр, нислэгийн тасалбар, үнэмлэх, крипто хөрөнгө зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ активыг нэг дороос удирдах боломжийг бүрдүүлдэг.

6. CURVE



Curve нь хэрэглэгчийн бүх банкны картуудыг нэг апп, нэг картаар нэгтгэн удирдах боломжийг олгодог онцлогтой. Тус үйлчилгээний /Go Back in Time/ функцийг тусламжтайгаар хэрэглэгч өмнө хийсэн гүйлгээг өөр карт руу буцаан шилжүүлэх боломжтой нь өрсөлдөх давуу тал болдог. Мөн 2025 онд “Lloyds Banking Group”-д нэгтгэгдсэнээр зах зээлийн цар хүрээгээ тэлж, илүү өргөн хэрэглээнд нэвтрэх стратегийн байр сууриа бэхжүүлж байна.

7. HUAWEI PAY



Huawei Pay нь интернет холболтгүй үед ч ажиллах боломжтой, төхөөрөмжийн түвшний шифрлэлтийг ашигладгаараа онцлог юм. Ингэснээр гүйлгээний мэдээлэл аюулгүй хадгалагдаж, оффлайн орчинд ч төлбөр хийх боломж бүрддэг. Мөн уг үйлчилгээ нь төлбөрийн карт, нийтийн тээврийн карт, байгууллагын нэвтрэх карт зэрэг олон төрлийн дижитал мэдээллийг нэг дороос удирдах боломжийг хэрэглэгчдэд олгодог.

8. ASTROPAY



AstroPay нь Латин Америк болон Азийн зах зээлд 200 гаруй орон нутгийн төлбөрийн аргыг

дэмждгээрээ онцлог бөгөөд бүс нутгийн онцлогт нийцсэн санхүүгийн шийдлийг санал болгодог. Ингэснээр уламжлалт банкны үйлчилгээ авч чадаагүй хэрэглэгчид орон нутгийн сувгаар хурдан, хялбар гүйлгээ хийх боломжийг бүрдүүлдэг.

9. GARMIN PAY



GARMIN PAY™

Garmin Pay нь ухаалаг цагтай шууд интеграцчилсан байдлаар ажилладаг бөгөөд гар утас авч явахгүйгээр /tap to pay/ буюу ойртуулж төлөх боломжийг олгодог. Энэ нь ялангуяа гүйх, дасгал хийх, аялал зугаалгаар явах зэрэг идэвхтэй амьдралын хэв маягтай хэрэглэгчдэд тохиромжтой. Мөн iOS болон Android үйлдлийн системтэй төхөөрөмжүүдтэй хоёулантай нь нийцэж ажилладгаараа давуу талтай.

10. Digiseq



Digiseq нь бөгж, түлхүүр зэрэг зүүж хэрэглэдэг төхөөрөмжүүдийг төлбөр хийх боломжоор хангаснаараа онцлогтой. Хэрэглэгч өөрийн утсаар эдгээр төхөөрөмжүүдийг бүртгэж, RCO буюу гар утас, ухаалаг цаг, бөгж гэх мэт төхөөрөмж дээр төлбөр хийх, мэдээллийг хамгаалах зориулалттай аюулгүй дижитал технологи ашиглан шифрлэгдсэн байдлаар аюулгүй төлбөр хийхэд ашиглах боломжтой бөгөөд ингэснээр гар утасгүйгээр төлбөр хийх уян хатан шийдлийг санал болгодог.

СУДЛААЧИЙН ИНДЭР

САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.

Гүйцэтгэсэн:

СЗХ, ЗЗСХГ, Ахлах референт, dashnyam_d@frc.mn
 СЗХ, ЗЗСХГ, Ахлах мэргэжилтэн, ninjbadgar@frc.mn
 СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, khulan@frc.mn
 СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, batnavch@frc.mn

ХУРААНГУЙ

Санхүүгийн нэгдэл нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн олон салбарыг хамарсан бүтэц бөгөөд эдийн засгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг. Санхүүгийн нэгдлийг оновчтой зохицуулах нь зах зээлийн эрсдэлийг бууруулж, зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Олон улсын санхүүгийн байгууллагууд санхүүгийн нэгдлийг хянах нийтлэг зарчим, аргачлалыг тодорхойлсон бөгөөд улс орнууд эдгээр зарчмуудыг үндэслэн эрх зүйн зохицуулалтын орчноо бүрдүүлж байна. Энэхүү судалгаанд Их Британи, Австрали, Сингапур, Япон, БНСУ зэрэг улсын туршлагыг авч үзсэн бөгөөд харьцуулсан дүн шинжилгээний үр дүнд санхүүгийн нэгдэл нь зах зээлийн үр ашигт эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ хяналт, зохицуулалт сул тохиолдолд системийн эрсдэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй болохыг харуулж байна.

Энэхүү судалгаа нь олон улсын санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын эрх зүйн орчны сайн туршлагыг харьцуулан судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит санал, зөвлөмжийг боловсруулахад чиглэсэн.

УДИРТГАЛ

Санхүүгийн нэгдэл нь үндэстэн дамнасан болон дотоодын гэсэн ерөнхий хэлбэртэй байх бөгөөд банк, даатгал эсхүл хөрөнгө оруулалтын компани давамгайлсан гэж ангилагдаж байна. Санхүүгийн нэгдэл нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбарын гол чиглэлүүдийг нэгтгэдэг бөгөөд тэдгээрийн харилцан уялдаа, нэгдлийн үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн тогтвортой байдалд шийдвэрлэх ач холбогдолтой (OECD, 2021). Санхүүгийн нэгдэл хяналт тавих оновчтой зохицуулалтын орчин бүрдүүлэх нь зах зээлийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, зах зээлийн оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх (FSB, 2022) болон хяналт шалгалтын нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой (OECD, 2021).

Олон улсын хэмжээнд санхүүгийн нэгдлийн зохицуулалт нь улс орнуудын эдийн засгийн онцлог, зах зээлийн бүтэц, санхүүгийн тогтолцооны хөгжилтэй уялдан ялгаатай байна (Basel committee on banking supervision, 2020). Гэсэн хэдий ч олон улсын санхүүгийн байгууллагууд, тухайлбал Олон улсын валютын сан (IMF), Дэлхийн банк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (FSB) зэрэг байгууллагууд санхүүгийн нэгдлийг зохицуулах нийтлэг зарчмуудыг тодорхойлсон байдаг (IMF, 2021). Эдгээр зарчмуудыг үндэслэн улс орнууд санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын арга механизм, эрх зүйн орчныг бүрдүүлдэг. Энэхүү судалгааны ажлаар Англи, Австрали, Сингапур, Япон, БНСУ зэрэг улсуудын санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын эрх зүйн орчин, олон улсын байгууллагуудаас гаргасан нийтлэг зарчим, зөвлөмжүүд болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, санал боловсруулахад чиглэнэ.

Санхүүгийн нэгдлийн хяналт, зохицуулалтын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлууд цөөнгүй бөгөөд дэлхий даяар эрсдэлийн мэдрэмжтэй, зарчимд суурилсан нэгдсэн хяналт, нэгтгэсэн тайлагналын тогтолцоо руу шилжиж буй хандлагыг илэрхийлж байна. Van Lelyveld ба Schilder нар (2002) банк, даатгал, үнэт цаасны үйл ажиллагааг нэгтгэсэн нэгдлүүдийн өсөлтөөс үүдэх системийн эрсдэл болон "хэт томоосоо болоод дампуурч болохгүй" (TBTF)–г онцолж, Basel II–ын хоёрдугаар тулгуурт нийцсэн онолын арга зүйг боловсруулсан нь анхны иж бүрэн шинжилгээний нэг болсон бол Fultanegara нар (2024) бүс нутгийн болон олон орны туршлага дээр тулгуурлан санхүүгийн нэгдлүүд нь эдийн засагт эерэг нөлөөтэй ч мэдээллийн ил тод байдал,

зохицуулалтгүй бүрэлдэхүүн хэсэгт хяналт тавих асуудлаар эрсдэлийн цоорхой үүсэж байгааг онцолж, хяналтын уялдаа холбоо, олон улсын хамтын ажиллагааны ач холбогдлыг тэмдэглэсэн. Харин Borsuk ба Dzuryk (2016) FICOD (“Financial Conglomerates Directive”, EU Directive 2002/87/EC) удирдамжийн хэрэгжилтийг шүүмжилж, SPV (Special Purpose Vehicle) болон финтек зэрэг зохицуулалтгүй хэсгүүдийг хяналтад хамруулах, толгой компанийн хяналтыг сайжруулах, хямралын үед төвлөрсөн хариу арга хэмжээ авах тогтолцоо шаардлагатайг дурдсан. Эдгээр нийтлэг зохицуулалт, хандлага нь эрсдэлийг цогцоор үнэлэх, олон улсын мэдээллийн солилцоог дэмжих, байгууллагын засаглал, дотоод хяналтыг сайжруулахад чиглэж байна.


Судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт санхүүгийн нэгдэл болон түүний хяналт шалгалтын тухай, хоёрдугаар бүлэгт олон улсын туршлага, Монгол Улсын өнөөгийн байдлыг тусгасан бол сүүлийн бүлэгт дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

САНХҮҮГИЙН НЭГДЭЛ БА ТҮҮНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОЙЛГОЛТ

Санхүүгийн нэгдлийн тодорхойлолт, ангилал

Санхүүгийн нэгдэл гэдэг нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбаруудыг хамарсан, нийтлэг удирдлага, эзэмшил дор үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын цогц бөгөөд санхүүгийн үйлчилгээний өргөн цар хүрээг хамарч, хөрөнгө оруулалтын олон төрлийн стратеги, үйл ажиллагааг нэгтгэдэг онцлогтой (OECD, 2021; FSB, 2022) гэж тодорхойлсон бол “Санхүүгийн нэгдэл” гэж банк, даатгал, ББСБ, хөрөнгө оруулалтын компани зэрэг санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хоёр ба түүнээс дээш байгууллага нь нэг толгой компанийн шууд болон шууд бус хяналт дор, харилцан уялдаатайгаар үйл ажиллагаа явуулж буй бүтцийг ойлгоно (Joint Forum, 2012; BCBS, 2021) гэжээ.

Зураг . Дэлхийн санхүүгийн зах зээл дэх санхүүгийн нэгдлийн ерөнхий бүтэц



Санхүүгийн нэгдлийн үүсэл, хөгжил

Эрт үе (19–р зууны сүүл – 20–р зууны эхэн үе): Санхүүгийн нэгдлийн гарал үүсэл нь 19–р зууны сүүлээс Европ, Америкийн томоохон банк, санхүүгийн байгууллагуудаас эхэлсэн байна. Энэ үед банк, даатгалын компани, хөрөнгө оруулалтын фирмүүд нь хууль эрх зүйн нарийн зохицуулалттай, харьцангуй тусдаа, бие даасан үйл ажиллагаа явуулдаг байж байгаад нэгджээ

Их хямрал ба зохицуулалтын үе (1930–1970–аад он): 1930–аад онд гарсан Их хямралын дараа, ялангуяа АНУ–д засгийн газраас санхүүгийн зах зээлийг хатуу зохицуулах болсон. Жишээлбэл, 1933 оны Glass–Steagall Act хуулиар банкнуудыг хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, банк, даатгал, хөрөнгө оруулалтын компаниудын хоорондын хил заагийг тодорхой заагласан нь санхүүгийн нэгдлийн хөгжлийг хязгаарласан байна.

Дэлхий нийтийн чөлөөлөлт, либералчлалын үе (1980–1990–ээд он): 1980–аад оноос дэлхийн санхүүгийн зах зээлд чөлөөлөлт өрнөж эхлэв. Энэ үеийн гол өөрчлөлтүүд:

- ◆ АНУ–д 1999 онд Gramm–Leach–Bliley Act батлагдан Glass–Steagall хуулийг цуцалж, банк, үнэт цаасны компани, даатгалын компаниуд хоорондоо нэгтгэх, худалдан авах боломжийг бүрдүүлсэн.
- ◆ Европын Холбоо нэгдсэн санхүүгийн зах зээлийг бий болгож, "универсал банкны" системийг дэмжиж, банк, даатгалын компаниудыг нэгтгэсэн "банк–даатгал" (bancassurance) бүтэц үүссэн.

Өргөжилтийн үе (2000–аад он): 2000–аад оны эхээр санхүүгийн нэгдлүүд асар хурдтай өргөжин, үйл ажиллагаа нь илүү нарийн төвөгтэй болсон:

- ◆ Банк, даатгал, хөрөнгө оруулалт, үнэт цаасны үйлчилгээ нэгтгэн үзүүлдэг томоохон глобал нэгдлүүд гарч ирсэн.
- ◆ Дериватив, бүтцийн санхүүгийн (structured finance) бүтээгдэхүүнүүдийг нэгдлүүдийн дотор өргөнөөр ашигласан.
- ◆ HSBC, JPMorgan Chase, BNP Paribas, Allianz зэрэг компаниуд олон улсад өргөн хүрээгээр үйл ажиллагаагаа тэлсэн.

Дэлхийн санхүүгийн хямрал ба зохицуулалтын шинэчлэл (2007–2009): 2007–2009 оны дэлхийн санхүүгийн хямрал нь томоохон санхүүгийн нэгдлүүдийн сул талыг ил болгосон. Citigroup, AIG, RBS зэрэг байгууллагуудын том хэмжээ, төвөгтэй бүтэц нь эдгээр компанийг засгийн газраас тусламж авах шаардлагыг бий болгосон.

Үүний хариуд дэлхий нийтээрээ зохицуулалтаа чангаруулсан:

- ◆ Базель III стандарт (2009–2010): Хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварын шалгуурыг нэмэгдүүлсэн.
- ◆ АНУ–ын Dodd–Frank хууль (2010): Системийн нөлөө бүхий санхүүгийн байгууллагуудад (SIFI) нарийн хяналт тавих болсон.
- ◆ Европын Solvency II журам (2016): Даатгал давамгайлсан нэгдлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулсан.

Хямралын дараах бүтэцлэлт ба дижитал шилжилт (2010–аас одоо хүртэл): Хямралын дараагаар санхүүгийн нэгдлүүд дахин бүтэцлэлт хийж, эрсдэл өндөртэй, үндсэн бус бизнесээ цөөлж эхэлсэн. Гэвч энэ үед дижитал санхүүгийн эрин эхэлсэн:

- ◆ Банк, финтек компани, даатгалын компани, хөрөнгө удирдлагын компаниуд хоорондоо хамтран ажиллаж эхэлсэн.
- ◆ Санхүүгийн нэгдлүүд цахим банк, төлбөр тооцоо, хөрөнгийн удирдлага, дижитал даатгал (insurtech)–ын салбарт хүчтэй орсон.

Одоогийн чиг хандлага, цаашдын төлөв (2020–иод оноос хойш): Санхүүгийн нэгдлүүд технологийн дэвшил, хууль эрх зүйн өөрчлөлт, дэлхийн өрсөлдөөнтэй холбоотойгоор тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байна. Үүнд:

- ◆ Дижиталчлал: Технологи, дата мэдээллийг ашиглан хэрэглэгчдэдээ нэгдсэн үйлчилгээ үзүүлэх болсон.
- ◆ Big Tech компаниудтай өрсөлдөх, тэдэнтэй хамтрах чиглэлээр илүү идэвхтэй ажиллаж байна (Google, Apple, Amazon, Facebook гэх мэт).
- ◆ Зохицуулалтын асуудлууд: Дэлхий даяар санхүүгийн тогтвортой байдал, цахим аюулгүй байдал, хэрэглэгчийг хамгаалах асуудлаар зохицуулалтаа улам чангаруулж байна.

Хяналт, шалгалтын чиг үүрэг, зорилго

Санхүүгийн нэгдэл нь эдийн засгийн үр ашиг, үйл ажиллагааны өртөг бууруулах боломжийг олгодог хэдий ч эрсдэлийн төвлөрөл, ашиг сонирхлын зөрчил зэрэг олон асуудал дагуулдаг (OECD, 2021). Тиймээс санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд зохистой хяналт, шалгалт, ил тод тайлагналын шаардлага тавигддаг (FSB, 2022).

Ангил (British Overseas Territory)–ийн Санхүүгийн үйлчилгээний хорооны (FSC) журамд дурдсанаар (R.S.A. с.F28 хуулийн 61 дүгээр зүйлд үндэслэн баталсан) жижиг боловч нэлээд хөгжсөн санхүүгийн орчинд “нэгдлийн хяналт шалгалт” гэдэг ойлголтыг хэрхэн авч үзэхийг томъёолжээ.

Журамд:

- ◆ **Хост /олон улсын/ зохицуулагчийн** (host regulator) үүрэг: Гадаадын байгууллагын салбар эсвэл охин компанид (branch/subsidiary) хяналт тавих,
- ◆ **Дотоодын /үндэсний/ зохицуулагчийн** (home regulator) үүрэг: Дотоодын санхүүгийн нэгдлийг нэгдсэн байдлаар хянах хэлбэрийн зохицуулалтын талаар дурдсан.

Санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, нэгдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, эрсдэлд тэсвэртэй байдлыг

бүрдүүлэхэд чиглэсэн чухал үүрэгтэй. Үндэсний болон олон улсын байгууллагууд (жишээлбэл, ОУВС, Дэлхийн банк, OECD, FSB) дараах үндсэн чиглэлүүдэд анхаарч байна. Үүнд:

Хүснэгт . Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянах чиглэл

Эрсдэлийн удирдлага ба хяналт	<ul style="list-style-type: none"> ◆ Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх, сайжруулах санал зөвлөмж өгөх ◆ Санхүүгийн нэгдлийн хэмжээнд эрсдэлийн төвлөрөл, хөрвөх чадвар, капиталын зохистой байдалд үнэлгээ өгөхөд оршино (OECD, 2021).
Санхүүгийн тогтвортой байдлыг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> ◆ Тэдгээрийн дампуурлаас үүдэх гинжин үр дагавраас урьдчилан сэргийлэх ◆ Тогтвортой, тасралтгүй санхүүжилтийн эх үүсвэрийг хадгалах ◆ Санхүүгийн зах зээлийн итгэлийг хадгалах, дунд хугацааны эрүүл өсөлтийг дэмжихэд оршино (World Bank, 2019).
Ил тод байдлын дэмжлэг	<ul style="list-style-type: none"> ◆ Санхүүгийн тайлан, удирдлагын тайлагналын чанарыг үнэлэх ◆ Хяналтын явцад илэрсэн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг бодлогын түвшинд хүргэх ◆ Зах зээлийн оролцогчдод шаардлагатай мэдээллийг нээлттэй, цаг хугацаанд нь хүргэхийг зорьдог (IMF, 2021).
Зах зээлийн сахилга бат ба хариуцлага	<ul style="list-style-type: none"> ◆ Удирдлагын хариуцлагыг тодорхой болгох ◆ Эрсдэл үүсгэгч үйлдэл, шийдвэрт зохих хариуцлага тооцох үндэслэл бүрдүүлэх ◆ Санхүүгийн сахилга бат, ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байхад чиглэнэ (FSB, 2022).

Эдгээр чиг үүрэг, зорилтууд нь зөвхөн тухайн санхүүгийн нэгдлийн дотоод үйл ажиллагааг төдийгүй, өргөн хүрээтэйгээр санхүүгийн системийн тогтвортой байдал, сайн засаглал, итгэлцлийг дэмжих болон эрсдэлийг бууруулах зохицуулалт бий болгох үндэс суурь болдог.

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Олон улсын байгууллагуудын зарчим, зөвлөмж

Санхүүгийн салбарын тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын байгууллагууд төрөл бүрийн стандарт, зөвлөмжийг боловсруулж, улс орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөдөг.

Joint forum нь Банкны хяналтын хороо (Basel Committee), Үнэт цаасны хяналтын олон улсын хороо (IOSCO), Даатгалын (IAIS) ийн хамтран үүсгэсэн байгууллага. Санхүүгийн нэгдлүүдийн холбоо хамаарлын түвшин нэмэгдэж, салбаруудын уялдаа гүнзгийрч байгаатай уялдуулан эдгээр нэгдлийг хэрхэн салбар хооронд зохицуулалттайгаар хянах, системийн эрсдэлийг бууруулах, хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог сайжруулах асуудлыг шийдвэрлэх нь зохицуулалтын гол зорилт болж байна. Иймд Joint forum ньСанхүүгийн нэгдлүүдийн капиталын нэгдсэн шаардлага, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, бүлгийн түвшний зохицуулалт зэрэгт чиглэсэн бодлогын удирдамж, “Core Principles”–ийг уялдуулах гарын авлага, судалгааны тайлан боловсруулж, үндэсний зохицуулагч байгууллагуудад сайн дурын хэрэгжүүлэлтийн хэлбэрээр танилцуулдаг.

Эдгээр зарчмууд нь олон улсын хэмжээнд санхүүгийн нэгдлүүдийг хянах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад зориулсан стандартчилсан аргачлал юм. Монголд одоогоор ийм түвшний нэгдсэн зохицуулалтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байгаа бөгөөд цаашид эдгээр зарчмуудыг нутагшуулах нь зүйтэй гэж үздэг байна.

Их Британи Улсын туршлага

Их Британи Улс нь санхүүгийн нэгдлийн тухай бие даасан хуульгүй бөгөөд дээрх хуулиуд, 2004 онд баталсан “Санхүүгийн нэгдэл ба бусад санхүүгийн бүлгийн зохицуулалтын журам”-аар зохицуулдаг. Энэхүү журам нь банк, даатгал, хөрөнгө оруулалтын салбарт зэрэг үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн нэгдлүүдийг нэгжийн түвшинд биш бүлгийн түвшинд хянах, зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлсэн журам юм. Тус журмын зорилго нь санхүүгийн нэгдлүүдийг бүлгийн түвшинд үр дүнтэй хянах, зохицуулах, салбар хоорондын эрсдэлийн тархалтаас урьдчилсан сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналтын давхардал болон цоорхойг арилгах зорилготой.

Хүснэгт . Их Британи Улсын санхүүгийн нэгдэл ба бусад санхүүгийн бүлгийн зохицуулалтын журам

№	БҮЛГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Тогтоолын нэр, хүчин төгөлдөр болох хугацаа, үндсэн нэр томъёоны утга тодорхойлсон.	“Санхүүгийн нэгдэл” гэдэг нь банк, хөрөнгө оруулалт, даатгалын үйл ажиллагаа явуулдаг ААН-г нэгтгэсэн, санхүүгийн салбарын олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг группийг хэлнэ. Групп гэдэгт толгой компани, түүний охин болон хамаарал бүхий компаниудыг хамаарна.
2	Санхүүгийн нэгдэл дэх хяналтын үйл ажиллагааны зохицуулагчийн үүрэг	Зохицуулагчийг сонгох шалгуур, санхүүгийн нэгдэл мэдэгдэх мөн санхүүгийн нэгдэл шалгуурыг биелүүлэхээс тагалзах нөхцөлийг заасан.
3	Нэмэлт хяналт тавих зорилгоор хуулийн IV хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Санхүүгийн нэгдлийн хяналтын хүрээнд эрх бүхий байгууллагуудын үүрэг
4	Санхүүгийн Үйлчилгээний тухай хуулийн 138А зүйлийн дагуух нэмэлт хяналт	Зах зээлийн дүрэм, шаардлага тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх тухай.
5	Томоохон хориг болон онцгой арга хэмжээний талаар зөвлөлдөх	Хяналтын байгууллагууд хоорондын мэдээлэл солилцож, харилцан уялдаатай хяналт хэрэгжүүлэх тухай.
6	Хяналтын байгууллагын үүрэг ба мэдэгдэл хүргүүлэх журам	Зохицуулагчийн үүрэг, мэдэгдлийг хүргүүлэх үйл явцын тухай.
7	Гадаад улсын санхүүгийн нэгдлийг хянах, зохицуулах	Гадаад улсын эрх бүхий байгууллага гэдэг нь Нэгдсэн Вант Улс (НВУ)-ын гадна оршиж, хуулиар хянах эрхтэй байгууллагыг хэлнэ. Гадаад улсын санхүүгийн нэгдэл гэдэг нь НВУ-ын гадна байрлах эцсийн хөрөнгө оруулагчтай группийг хэлнэ.
8	Гадаад улсын санхүүгийн нэгдлийг хянах	Гадаад улсын санхүүгийн нэгдэл дэх зохицуулалттай этгээдийг хянахдаа зохицуулагч нь бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, тодорхой арга хэмжээ авахын өмнө зөвшөөрөл авах шаардлагатай.
9	Гадаад улсын банкны группийг хянан зохицуулах	Гадаад улсын банкны группийг хянахдаа зохицуулагч нь бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, тодорхой арга хэмжээ авахын өмнө зөвшилцөх шаардлагатай.
10	Гадаад улсын группийг CRD, CRR дагуу хянах	Гадаад улсын группийг капитал шаардлагын журам (CRR) болон капитал шаардлагын удирдамж (CRD)-ийн дагуу хянах.
11	Нууц мэдээллийг задруулахгүй байх журам	Санхүүгийн нэгдэлтэй холбоотой нууц мэдээллийн зохицуулалт
12	Мэдээлэл цуглуулахдаа давхар тайлагналаас зайлсхийх	Мэдээлэл цуглуулахдаа зохицуулагч байгууллагууд мэдээллийг дахин шаардахгүй байх, тайлагналын давхардлыг үүсгэхгүй байх зарчмыг баримтлах ёстой.
13	Хөрөнгийн хүрэлцээ	Компаниудын нийлсэн хөрөнгө дээр үндэслэн хөрөнгийн зохистой байдлын шаардлагыг тавьдаг.

Австрали Улсын туршлага

Австралийн санхүүгийн хяналт шалгалтын тогтолцоо нь 1998 онд "Wallis Inquiry"-ийн дүгнэлтээр үндэслэгдэн шинэчлэгдэж, санхүүгийн зохистой хяналтын байгууллага болох APRA байгуулагдсан. Өмнө нь салбар тус бүрд хяналт тавьдаг байсан бол 1998 оноос хойш банк, даатгал, тэтгэврийн салбарт нэгдсэн зохистой хяналтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. 2017 оны шинэчлэлээр эрсдэлийн удирдлага, байгууллагын засаглал, ил тод байдал зэрэгт илүү нарийвчилсан стандартууд тогтоосон.

Хүснэгт . Австрали Улсын санхүүгийн нэгдлийн /Level-3/ хяналт шалгалтын стандарт, зөвлөмж

СТАНДАРТЫН КОД	СТАНДАРТЫН НЭР	ХАМРАХ АГУУЛГА
3PS001	Нэр томъёоны тодорхойлолт	(APRA)-аас гаргасан зохицуулалтын стандартуудын хүрээнд хэрэглэгдэх гол нэр томъёонуудыг тодорхойлсон баримт бичиг юм. Энэхүү стандарт нь Level 3 толгой байгууллагуудад хамаарах бусад зохицуулалтын стандартуудыг зөв ойлгож хэрэглэхэд шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтыг агуулдаг.
3PS110	Хөрөнгийн зохистой байдал	Хөрөнгийн зохистой байдлыг хангах үүргийг тодорхойлдог. Хөрөнгийн удирдлагын бодлого, ICAAP, салбар тус бүрийн эрсдэлд нийцүүлэн нийт капиталын шаардлагыг тооцох, дотоод гүйлгээ болон тайлагналын ил тод байдал зэргийг тусгасан.
3PS221	Aggregate Risk Exposures Эрсдэлийн хяналтын практик зөвлөмжүүд	Эрсдэлийг тодорхойлж, хэмжих, хянах, тайлагнах, хязгаарлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, Зах зээлийн нөхцөл байдал, гол эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлтүүдийн нөлөөг урьдчилан таамаглах зорилгоор ирээдүйг харсан шинжилгээ, стресс тест хийх зэргийг тусгасан.
3PS222	Intra-group Transactions and Exposures Дотоод гүйлгээний практик зөвлөмжүүд	Санхүүгийн групп доторх байгууллагуудын хоорондын гүйлгээ, хамаарлаас үүдэлтэй эрсдэлийг хэрхэн тодорхойлох, үнэлэх, хянах зэрэгт өгсөн зөвлөмж багтана. Зарим төрлийн дотоод гүйлгээнд эрсдэлийн хязгаар (exposure limits) тогтоож, группийн санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлнэ.
3PS310	Audit and Related Matters Аудит	Аудитын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж, аудитын үр дүнг APRA-д шууд хүргүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн мэдээллийн найдвартай байдлыг хангах зорилготой.

Азийн орнуудын туршлага (Сингапур Улс, Япон Улс, Өмнөд Солонгос Улс)

Сингапур Улс

Сингапур Улс нь 2013 онд "Санхүүгийн холдинг компанийн тухай хууль"-ийг баталснаар санхүүгийн нэгдлийг хянах, зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Тус хуульд:

"Financial holding company" (санхүүгийн холдинг компани): "Санхүүгийн холдинг компани" гэж дараах шаардлагыг хангасан холдинг компанийг хэлнэ:

- (а) Сингапурт үүсгэн байгуулагдсан банк эсхүл Сингапурт байгуулагдсан, бүртгэгдсэн эсхүл үүсгэн байгуулагдсан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь дор хаяж нэг охин компани эзэмшдэг байх;
- (б) Тус охин компани (эсхүл санхүүгийн байгууллагын статустай охин компаниуд нийлсэн байдлаар) нь уг холдинг компанийн нийт хөрөнгө, капитал, өр төлбөр эсхүл орлогын 50 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг байх." гэж тусгасан.

Хүснэгт . Сингапур Улсын Санхүүгийн холдингийн тухай хууль, 2013

№	БҮЛГИЙН НЭР	ТАЙЛБАР
1	Удиртгал	Хуулийн нэр, хэрэгжиж эхлэх хугацаа, нэр томъёо болон үндсэн ойлголтыг тодорхойлсон хэсэг.
2	Мэдээлэл авах эрх	Санхүүгийн зохицуулагч байгууллага нь санхүүгийн холдинг компаниудаас шаардлагатай мэдээллийг авч, хяналт тавих эрхтэй байгааг заасан.
3	Санхүүгийн холдинг компанийг томилох	Зохицуулагч байгууллага (MAS) тодорхой нөхцөлд компанийг “санхүүгийн холдинг компани” гэж нэрлэх, бүртгэх, холдинг байх нэршлийг хүчингүй болгох, нэр ашиглахыг хориглох, үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох харилцааг зохицуулна.
4	Хувьцаа болон хяналтын багцын өөрчлөлт	Банкны охин компани эсэхээс хамааран томоохон хувьцаа эзэмшил, саналын эрх, хяналтын багц шилжүүлэх, урьдчилсан зөвшөөрөл авах, давж заалдах эрх зэрэг хувьцааны харилцааг зохицуулна.
5	Эрсдэл ба хөрөнгө оруулалтын хязгаар	Хэт их эрсдэлээс сэргийлэх, удирдлагын ашиг сонирхлын мэдүүлэг, хувьцаа болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын дээд хязгаарыг тогтооно.
6	Өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангах шаардлага	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, капиталын доод хэмжээ, капиталын хүрэлцээ, хөшүүрэг, тэдгээрийн хэрэгжилтийг хянах эрхийг зохицуулна.
7	Аудит, хяналт шалгалт ба мөрдөн шалгалт	Жилийн аудит, группийн оролцогч компаниудад шалгалт хийх, тусгай мөрдөн шалгалт явуулах, гадаад хяналтын байгууллагатай хамтран ажиллах, шалгалтын нууцлалыг хамгаалах заалтууд орно.
8	Холдинг компанид хяналт тогтоох эрх	Дампуурах нөхцөл үүссэн үед зохицуулагч байгууллага хяналт тогтоох, үр дагавар, хугацаа, албан тушаалтны хариуцлага, татан буулгах журмыг тодорхойлно.
9	Гадаад зохицуулагч байгууллагад туслалцаа үзүүлэх	Гадаад зохицуулагч байгууллагуудад мэдээлэл өгөх, хамтран ажиллах нөхцөл, эрх зүйн хамгаалалт, хариуцлага, зөрчлийн заалтуудыг зохицуулна.
10	Бусад зохицуулалт	Журам батлах, мэдэгдэл хүргэх, гүйцэтгэх захирал томилох/чөлөөлөх, албан тушаалтанд хариуцлага тооцох, шүүхийн харьяалал, прокурорын зөвшөөрөл, бусад холбогдох зохицуулалтуудыг багтаана.

Япон Улс

Япон Улс одоогоор санхүүгийн нэгдлүүдийн хяналтыг нэг зөвлөмжөөр бус, салбар тус бүрийн нарийвчилсан журам, заавруудын дагуу хяналт шалгалтаа явуулж байна. Олон салбар хамарсан буюу банк, даатгал, үнэт цаас зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг бол “Key matters in examining Liquidity Risk Management at Large Complex Financial Groups” гэсэн стандартыг баримтлан хяналт шалгалтаа хийж байна.

"Comprehensive Guidelines for Supervision of Financial Instruments Business Operators, etc." (Санхүүгийн хэрэгслийн бизнес эрхлэгчдийг хянах иж бүрэн удирдамж) нь Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA)-аас боловсруулсан баримт бичиг бөгөөд санхүүгийн оролцогчдыг хянах, зохицуулах үндсэн зарчмуудыг тодорхойлдог.

Өмнөд Солонгос Улс

Санхүүгийн конгломератууд (Financial Conglomerates)-д Санхүүгийн Хяналтын газар (Financial Supervisory Service, FSS) хяналт тавьдаг ба Санхүүгийн үйлчилгээний хорооны удирдамжийн дагуу ажилладаг. Өөрөөр хэлбэл санхүүгийн нэгдлийн хяналтыг Санхүүгийн Хяналтын газар хариуцдаг ба бодлогын, үйл ажиллагааны түвшинд Санхүүгийн үйлчилгээний хороо хариуцдаг. Санхүүгийн хяналтын газар (Financial Supervisory Service, FSS) нь Төв банкнаас бүрэн бие даасан, тусдаа статустай байгууллага ба Санхүүгийн үйлчилгээний хороонд харьяалагддаг. Санхүүгийн үйлчилгээний хороо нь ерөнхий сайдын харьяа төрийн байгууллага юм. Энэ нь төрд харьяалагддаг хэлбэр гэдгээрээ бусад өндөр хөгжилтэй орнуудын SSA загвараас ялгаатай.

Хүснэгт . Солонгос Улсын Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хууль, 2021

№	Бүлгийн нэр	Тайлбар
1	Ерөнхий дүрэм журам	Хуулийн зорилго, нэр томъёо болон үндсэн ойлголтыг тодорхойлсон хэсэг
2	Санхүүгийн олон талт байгууллагыг тодорхойлох зэрэг	Холбогдох этгээдүүдийн үүрэг, холбогдох этгээдийн хасалт буюу өөрчлөлтийн тухай мөн зохицуулагчийн үүрэг, хариуцлагын талаар заасан байна.
3	Дотоод хяналт ба эрсдэлийн удирдлага	Санхүүгийн нэгдэл дэх дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын систем, хөрөнгийн зохистой түвшин, дотоод хэлцэл болон эрсдэлийн төвлөрөл, эрсдэлийн шилжилт зэрэг өргөн хүрээг хамарсан гол бодлогын чиглэлүүдийг тусгасан.
4	Санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалт	Санхүүгийн нэгдэл дэх хяналт, шалгалт, тогтвортой байдал, эрсдэлийн удирдлага, ил тод байдал, хяналт шалгалт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол зарчмуудыг тусгасан.
5	Шийтгэл ба захиргааны арга хэмжээний журам	Хууль зөрчсөн үйлдэлд зохистой арга хэмжээ авах, зөрчлийг арилгуулах, сануулга өгөх болон хориг тавих замаар дахин зөрчил гаргах эрсдэлийг бууруулах явдал юм.
6	Нэмэлт заалтууд	Санхүүгийн группийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Захиргааны арга хэмжээг ил тод байлгах, Хууль хэрэгжүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх.
7	Торгууль ба эрүүгийн шийтгэл	Санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг баталгаажуулах, Дотоод мэдээллийг хамгаалах, Хууль зөрчсөн этгээдүүдэд шийтгэл оногдуулах эрх зүйн үндэс бүрдүүлэх.

Ийнхүү санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын олон улсын туршлагаас үзэхэд Их Британи, Австрали улс *хосолсон загвар* (Twin Peaks Approach), харин Солонгос, Сингапур улс *нэгдсэн загвар* (Integrated Approach) хэрэгжүүлж байна. Япон улс уламжлалт *институционал загварыг* (Institutional Approach) хадгалж байгаа ч нэгдсэн хяналтын элементүүдийг агуулсан байна. Ихэнх орнууд *эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлал* (risk-based supervision) нэвтрүүлж, макро зохистой байдлын шинжилгээ болон группийн түвшинд хөрөнгийн үнэлгээ, стресс тест зэрэг интеграцчилсан үнэлгээний арга зүйг ашиглаж байна.

Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсад санхүүгийн нэгдэл нь 2010 оны Банкны тухай хуулийн 6.2–д зааснаар банк нь Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгөөр санхүүгийн бусад салбар үйл ажиллагаа, үүнд: санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, итгэлцлийн үйлчилгээ, даатгалын зуучлагч, андеррайтерын үйлчилгээ, кастодиан, факторингийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг эрхэлж болохоор хуульчилснаар үүссэн. Санхүүгийн салбарын хуулиудад Санхүүгийн нэгдлийн тусгайлсан хууль, журам байхгүй бөгөөд салбар тус бүрийн хууль, журмаар хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн нэгдэл гэдэг нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбаруудыг нэгтгэсэн, нэгдсэн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг цогц бүтэц юм. Энэхүү бүтцийн үүсэл хөгжил, түүхэн хувьсал нь дэлхийн эдийн засгийн хөгжил, санхүүгийн либералчлал, технологийн дэвшил, хууль эрх зүйн өөрчлөлтийн суурь нөхцөлд үндэслэгдэн өргөжиж ирсэн. Тухайлбал, 2007–2009 оны дэлхийн санхүүгийн хямрал нь хэт том, төвөгтэй бүтэц бүхий санхүүгийн нэгдлүүдийн зохицуулалтыг сайжруулах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагыг ил тод харуулсан. Үүний улмаас санхүүгийн нэгдэлд чиглэсэн хяналт шалгалтын гол зорилго нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Олон улсын туршлагаас харвал санхүүгийн нэгдлийг хянах тогтолцооны бүтэц, хэрэгжүүлэлтийн аргачлал улс орон бүрд харилцан адилгүй боловч нийтлэг зарчим, чиг хандлага ажиглагддаг. Жишээлбэл, Их Британи, Австрали улс “Twin Peaks” загварыг хэрэгжүүлж, зохистой хяналт ба зах зээлийн зохицуулалтыг тусгаарлан гүйцэтгэдэг бол Сингапурт төвлөрсөн зохицуулалтын бүтэц (MAS), Японд салбар тус бүрд чиглэсэн нарийвчилсан удирдамж, БНСУ–д шаталсан бүтэц бүхий нэгдсэн хяналтын тогтолцоо үйлчилдэг. Эдгээр улс орны хяналтын арга зүйд эрсдэлд суурилсан хандлага давамгайлан хэрэглэгддэг. Мөн Joint Forum, Solvency II зэрэг олон улсын байгууллагуудын боловсруулсан зарчим, удирдамж нь санхүүгийн нэгдлийн бүлгийн түвшний зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад чиглэж, улс орнуудын хяналтын тогтолцооны уялдаа холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Монгол Улсад банкны салбарын хяналт шалгалтыг

Монголбанк, банкнаас бусад санхүүгийн байгууллагын хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна. Гэвч санхүүгийн нэгдэлтэй холбоотой тусгайлсан, цогц эрх зүйн зохицуулалт хараахан бүрдээгүй бөгөөд Компанийн тухай болон Банкны тухай хуульд хэсэгчлэн тусгасан байдалтай байна. Энэ нь нэгдлийн түвшинд эрсдэлийг үнэлэх, тайлагнах, хянах үйл ажиллагаанд институц хоорондын уялдаа, мэдээллийн нэгдмэл байдал, тайлагналын ил тод байдал хангалтгүй байгааг илтгэдэг.

Иймд Монгол Улсад санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын сайн туршлага, зарчмуудыг үе шаттайгаар нутагшуулах шаардлага улам бүр чухал болж байна. Үүнд, хууль эрх зүйн шинэчлэл хийх, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, мэдээлэл солилцооны механизмыг сайжруулах, компанийн бүртгэлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, нэгдсэн тайлагналын тогтолцоог бий болгох зэрэг нь хяналтын үр дүнг бодитоор сайжруулах үндэс болно. Түүнчлэн стресс тест, ICAAP, ORSA зэрэг аргачлалуудыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах замаар санхүүгийн нэгдлүүдийн эрсдэлийг системийн түвшинд удирдах боломжтой. Иймд санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын зохицуулалт, туршлагад үндэслэн дараах саналыг боловсрууллаа.

- ◆ Санхүүгийн нэгдлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн нэгдлийн оролцогч байгууллагуудын хамрах хүрээг тодорхойлох;
- ◆ Тусгайлсан хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэн олон улсын “Joint forum”-ын зарчимд суурилан санхүүгийн нэгдэлд зориулсан зайны болон газар дээрх хяналт шалгалтын аргачлалыг боловсруулах;
- ◆ Санхүүгийн нэгдэл, түүний охин компанийн бүртгэлийн мэдээллийг нэгтгэх нэгдсэн платформыг бий болгох /Улсын бүртгэлийн газарт бүртгэлтэй/.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ “Anguilla Financial Services Commission. (2017). Guidelines: Consolidated Supervision (Issued under Section 61 of the Financial Services Commission Act, R.S.A. c.F28).
- ◆ Accounting Standards Council Singapore. (2023). Statutory Board Financial Reporting Standard 110: Consolidated Financial Statements. <https://www.asc.gov.sg>
- ◆ AHRP Law Firm. (2024, December 28). Financial Conglomerate and Financial Holding Company Based on OJK Regulation No. 30/2024.
- ◆ Banking Supervision – European Central Bank. (2024, January). Guide on reporting of significant risk concentrations and intra-group transactions for financial conglomerates. European Central Bank.


- ◆ Barbosa, Klknio & Rocha, Bruno & Salazar, Fernando. (2014). Assessing Competition in the Banking Industry: A Multi-Product Approach. *Journal of Banking & Finance*. 50. 10.1016/j.jbankfin.2014.05.003.
- ◆ Basel Committee on Banking Supervision (2010). *Basel III: International Framework for Liquidity Risk Measurement, Standards, and Monitoring*.
- ◆ Borsuk, M., & Duryk, A. (2016). Position of the European Financial Congress on the supplementary supervision of financial conglomerates. *Bezpieczny Bank (Safe Bank)*, 4(65), 116–144.
- ◆ Chien, W. H., & Wang, Y. L. (2024, December). Overcoming class imbalance in financial supervision: A generative adversarial approach. *arXiv Preprint*. <https://arxiv.org/abs/2412.15222>
- ◆ Consolidated_Supervision_of_Banks_and_Fi.pdf. (n.d.). Handbook for Regulators and Supervisors on Consolidated Supervision of Banks and Financial Conglomerates. consolidated-sup14.pdf. (n.d.). Regulatory Requirements for Consolidated Supervision of Investment Businesses. document.pdf. (n.d.). Supplementary Supervision of Financial Conglomerates: European Policy Perspective.
- ◆ European Commission. (2014). Application of the calculation methods of capital adequacy requirements for financial conglomerates (Commission Delegated Regulation (EU) No 342/2014, as amended, including by the Technical Standards (Financial Conglomerates) (EU Exit) Instrument 2019). *Official Journal of the European Union*.
- ◆ European Commission. (2015). Definitions and coordinating the supplementary supervision of risk concentration and intra-group transactions (Commission Delegated Regulation (EU) 2015/2303, as amended, including by the Technical Standards (Financial Conglomerates) (EU Exit) Instrument 2019, Annex B, and the PRA Technical Standards (Consequential Amendments) (EU Exit) Instrument 2020). *Official Journal of the European Union*.
- ◆ Federal Reserve Board. (2024, November). *Supervision and Regulation Report*. <https://www.federalreserve.gov/publications/2024-november-supervision-and-regulation-report.htm>
- ◆ Gramm-Leach-Bliley Act (1999), United States Congress.
- ◆ Group-Wide_Consolidated_Supervision_in_Bank_and_Financial_Groups.pdf. (n.d.). Group-Wide Risk Assessment in Bank and Financial Conglomerates.
- ◆ Hutton, Georgina, et al. (2022). *Financial Services: Contribution to the UK Economy*. *Parliament.uk*. researchbriefings.files.parliament.uk/documents/SN06193/SN06193.pdf.
- ◆ IFRS Foundation. (2022). *IFRS 10 Consolidated Financial Statements: Basis for Conclusions (January 2022) [PDF file]*. IFRS Foundation. (Original work published 2011 [for IFRS 10], updated 2022.)
- ◆ Prudential Regulation Authority. (2004). *Financial conglomerates (PRA Rules, Chapter 12)*. In *The Financial Conglomerates and Other Financial Groups Regulations 2004*. UK Legislation.
- ◆ RegulatoryPolicy-ConsolidatedSupervisionNov2023_1700579536.pdf. (n.d.). Group-Wide Supervision Requirements under Cayman Islands Regulatory Policy.
- ◆ Reuters. (2025, April 8). *FINMA to be more active in future, says Swiss regulator after Credit Suisse crisis*. <https://www.reuters.com/business/finance/finma-will-be-more-active-future-swiss-regulator-says-2025-04-08>
- ◆ Rysin, V., Galenko, O., Duchynska, N., et al. (2021). *Financial Convergence as a Mechanism for Modifying Sectors of the Global Financial Services Market*. *Universal Journal of Accounting and Finance*.
- ◆ SB-FRS_110_(2023).pdf. (n.d.). *Singapore Standard SB-FRS 110: Consolidated Financial Statements*.
- ◆ Scott, D. H. (1995). *Regulation and Supervision of Financial Conglomerates*. World Bank
- ◆ Toronto Centre. (2016). *Group-Wide Consolidated Supervision in Bank and Financial Groups*.
- ◆ World Bank. (1995). *Regulation and Supervision of Financial Conglomerates (FPD Note No. 36)*. Washington, D.C.: The World Bank.



ҮНЭТ ЦААСЫГ ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаа нь үнэт цаасыг гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, нэг тал нөгөө талд шилжүүлж, хугацаа дуусахад ижил төрлийн, ижил тоо ширхэгтэй үнэт цаасыг хүүгийн хамт буцаан өгөх үүрэг бүхий санхүүгийн ажиллагаа юм.



Уг үйлчилгээг үнэт цаасны номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй үнэт цаасны компани дараах харилцагчдад үзүүлнэ. Үүнд:



Сүүлийн 1 жилийн сарын дундаж орлого 10 сая болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл 500 сая төгрөгөөс дээш хэмжээний цэвэр хөрөнгөтэй Монгол Улсын иргэн;



Сүүлийн 3 жилийн аль 1 жилийн борлуулалтын орлого нь 2.5 тэрбум төгрөгөөс доошгүй, өөрийн хөрөнгийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс доошгүй Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд;



Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд;



Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагууд, Төвбанк, Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Засгийн газрын тусгай сан, Зээлийн батлан даалтын сан, бүх төрлийн даатгалын сан.

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ТАЛ:



Мэргэжлийн хөрөнгө оруулагчид үнэт цаасаа зээлдүүлэх замаар нэмэлт орлого олох



Хөрөнгө оруулалтын багцаа үр ашигтай удирдах



Арилжааны идэвх, зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдэх



Гадаадын болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ГЭРЭЭНД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ЗААВАЛ ТУСГАНА:



Талуудын албан ёсны нэр, хаяг, регистрийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл;



Зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, төрөл тус бүрийн болон нийт үнийн дүн;



Барьцаа хөрөнгийн болон барьцаа хөрөнгө үнэт цаас байх тохиолдолд хорогдуулалтын хувь;



Барьцаанд тавьсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах тохиолдолд хүү тооцож эхлэх болон дуусах өдөр;



Үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээ, төлөх давтамж, тооцож эхлэх хугацаа;



Зээлийн хугацаа;



Талуудын эрх, үүрэг, хариуцлага

Дараах QR кодыг уншуулан “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам”-тай танилцана уу.



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ИЕН СУЛРАХАД ВОЈ БОДЛОГЫН ХҮҮГЭЭ
НЭМЭГДҮҮЛЭХ ҮҮ?



ТОКИО, 2-р сарын 23 – Японы Төв банк (BOJ) иений ханш дахин огцом сулрах тохиолдолд гуравдугаар сард бодлогын хүүгээ нэмэгдүүлэх боломжтой гэж тус банкны Удирдах зөвлөлийн гишүүн асан Макото Сакүрай мэдэгдлээ.

Түүний хэлснээр, иен сулрах нь импортын үнийг өсгөж, инфляцыг нэмэгдүүлдэг тул ханшийг хамгаалах хамгийн үр дүнтэй арга нь валютын интервенц бус, бодлогын хүүг өсгөх явдал юм.

Одоогийн бодлогын хүү 0.75% байгаа бөгөөд эдийн засагчдын олонх нь зургаадугаар сар гэхэд 1% хүрнэ гэж үзэж байна. Зах зээл дөрөвдүгээр сар гэхэд хүү нэмэгдэх 70% магадлалтай гэж үнэлжээ.

Сакүрайн үзэж буйгаар, 2026–2027 онд хүүг үе шаттайгаар нэмэгдүүлж 1.75% хүргэж магадгүй. Гэхдээ хүүг хэт хурдтай өсгөвөл жижиг компаниуд болон орон нутгийн банкнуудад сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Иений сулрал нь өрхийн зардлыг нэмэгдүүлж байгаа тул энэ нь Японы бодлого боловсруулагчдын хувьд улс төрийн эмзэг асуудал болоод байна.

Эх сурвалж: www.reuters.com

АНУ-ЫН ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛД НӨӨЦ БАГАСЧ,
ИПОТЕКИЙН ХҮҮ БУУРЧЭЭ.



ВАШИНГТОН, 2-р сарын 20 – АНУ-д шинэ орон сууцны борлуулалт 12-р сард буурсан ч барилга эрхлэгчид илүүдэл нөөцөө багасгах чиглэлд ахиц гаргасан нь цаашид шинэ орон сууцны төслүүд эхлүүлэх боломжийг нэмэгдүүлж магадгүй байна.

АНУ-ын Худалдааны яамны Хүн ам, тооллогын товчооны мэдээлснээр, шинэ орон сууцны борлуулалт 12-р сард 1.7 хувиар буурч, 745,000 нэгж болсон байна. Харин 11-р сард борлуулалт 758,000 нэгжид хүрч, 10-р сарын 656,000 нэгжээс өссөн үзүүлэлттэй байжээ. Энэхүү мэдээлэл нь өнгөрсөн жил Засгийн газрын үйл ажиллагаа түр зогссонтой холбоотойгоор хойшлогдсон юм.

Шинэ орон сууцны борлуулалт нь АНУ-ын нийт орон сууцны зах зээлийн бага хувийг эзэлдэг бөгөөд сар бүр ихээхэн хэлбэлзэлтэй байдаг. Борлуулалтыг гэрээ байгуулсан мөчөөр тооцдог. Гэсэн хэдий ч 12-р сарын борлуулалт өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн байна.

Зах зээл дээрх шинэ орон сууцны нөөц 12-р сард 485,000 нэгжээс 472,000 нэгж болж буурсан байна. Баригдаж буй орон сууцны нөөц бараг 4 жил хагасын доод түвшинд хүрчээ. 12-р сарын борлуулалтын хурдаар тооцвол зах зээл дээр байгаа шинэ орон сууцыг бүрэн зарахад 7.6 сар шаардагдах бөгөөд энэ нь 11-р сарын 7.7 сараас бага үзүүлэлт юм.

Орон сууцны зах зээлд ипотекийн зээлийн хүү буурсан нь эерэг нөлөө үзүүлж магадгүй байна. 30 жилийн хугацаатай

тогтмол хүүтэй ипотекийн зээлийн дундаж хүү энэ долоо хоногт 6.01 хувь болж буурсан нь 2022 оны 9-р сараас хойших хамгийн доод түвшин бөгөөд өмнөх долоо хоногт 6.09 хувь байсан гэж ипотекийн санхүүжилтийн байгууллага Freddie Mac мэдээлжээ.

Эх сурвалж: www.reuters.com

ХОНКОНГ ТӨСВИЙН АЛДАГДЛААС АШИГ РУУ: ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ ОРЛОГЫГ ТЭЛЭВ.



Хонконг сүүлийн хорин жилийн хугацаанд хамгийн удаан үргэлжилсэн төсвийн алдагдлаа эцэслэх боломжийн ирмэг дээр ирээд байна. Хөрөнгийн зах зээлийн огцом сэргэлт болон шимтгэлийн (stamp duty) орлогын мэдэгдэхүйц өсөлт нь өнгөрсөн онд бүртгэгдсэн 67 тэрбум хонконг долларын алдагдлыг анх төлөвлөснөөс хавьгүй хэмжээгээр бууруулжээ. Ийм нөхцөлд төсөв бага хэмжээний ашигтай гарах магадлал ч бодитоор нэмэгдэж байна.

2025 онд Hang Seng индекс 28%-иар өсөж, өдрийн дундаж арилжаа 272 тэрбум хонконг долларт хүрсэн нь Засгийн газрын орлогыг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн. IPO зах зээл идэвхжиж, олон зуун компани хөрөнгийн биржид бүртгүүлэхээр хүлээгдэж байгаа нь орлогын тогтвортой эх үүсвэрийг хадгалах боломжийг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ Хятадын хөрөнгө оруулагчдын идэвх нэмэгдсэн нь зах зээлийн эргэлтийг дэмжиж байна.

Гэсэн ч Сангийн нарийн бичгийн дарга болгоомжтой байр суурь баримталж байна. АНУ-ын тарифын тодорхойгүй байдал болон эх газрын Хятадын эдийн засгийн удаашрал нь гадаад эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй. Мөн дэд бүтцийн томоохон төслүүд, ялангуяа Northern Metropolis төслийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар бонд гарган

санхүүжилт татах шаардлагатай хэвээр байна.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл сэргэж, газрын борлуулалтын орлого өссөн ч цаашид уг салбарыг бодлогоор дэмжих боломж хязгаарлагдмал болсон. Иймээс Засгийн газар богино хугацааны өдөөлтийн арга хэмжээнээс илүү урт хугацааны өрсөлдөх чадвар, технологийн хөгжил болон төсвийн сахилга батыг чухалчлах төлөвтэй байна.

Эх сурвалж: www.reuters.com

PEOPLE'S BANK OF CHINA ЖИШИГ ЗЭЭЛИЙН ХҮҮГ ЕС ДЭХ САР ДАРААЛАН ӨӨРЧЛӨЛТГҮЙ ХАДГАЛЛАА

ШАНХАЙ, 2 дугаар сарын 24 – БНХАУ 2 дугаар сард жишиг зээлийн хүүгээ ес дэх сар дараалан өөрчлөлтгүй хэвээр үлдээлээ.

БНХАУ 2025 онд ойролцоогоор 5 хувийн эдийн засгийн өсөлтийн зорилтоо экспортын өсөлтийн нөлөөгөөр биелүүлсэн хэдий ч бүтцийн тэнцвэргүй байдал, худалдааны маргаан, геополитикийн тодорхойгүй байдал нь цаашдын төлөвийг бүрхэг болгож байна. Reuters агентлагийн таамаглалаар эдийн засгийн өсөлт 2026 онд 4.5 хувь хүртэл саарах төлөвтэй байна.

1 жилийн хугацаатай зээлийн үндсэн хүү (LPR) – 3.0 хувь (өөрчлөгдөөгүй)

5 жилийн хугацаатай зээлийн үндсэн хүү (LPR) – 3.5 хувь (өөрчлөгдөөгүй)

БНХАУ-ын Төв банк болох People's Bank of China дотоодын эрэлтийг идэвхжүүлэх чиглэлээр санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх бодлого баримтлахаа мэдэгдсэн. Үйлдвэрлэлийн салбар дахь илүүдэл хүчин чадал, хэрэглээний идэвх сул хэвээр байгаа нь бизнесийн итгэлд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөвийг хязгаарлаж байна.

Өнгөрсөн сард тус Төв банк мөнгөний бодлогын бүтэцчилсэн хэрэгслүүдийн хүүг 25 суурь нэгжээр бууруулсан бөгөөд энэхүү арга хэмжээ нь жишиг хүүг бууруулсантай харьцуулахад эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө харьцангуй бага гэж шинжээчид үзэж байна. Түүнчлэн энэ онд банкнуудын заавал байлгах нөөцийн харьцаа (RRR)-г бууруулах болон бодлогын хүүг илүү өргөн хүрээнд танах боломж нээлттэй байгааг илэрхийлсэн.

Эх сурвалж: www.reuters.com

АНУ–ИРАН ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР АНХААРЛЫН ТӨВД БАЙХ ҮЕД АЛТНЫ ҮНЭ ДАХИН ӨСӨВ

Алт болон мөнгөний үнэ өссөн нь АНУ Ойрхи Дорнодод цэргийн хүчээ нэмэгдүүлж буйтай холбоотойгоор зах зээлд түгшүүр бий болж, хөрөнгө оруулагчид “аюулгүй хөрөнгө” буюу алтруу хөрөнгө оруулж байна.

Алтны үнэ унц нь 5,200 ам.доллараас давж, сар тутмын өсөлтөө баталгаажуулав. Зуучлагч Оман Улсын мэдээлснээр, Вашингтон болон Тегеран “чухал ахиц” гаргасан тул хэлэлцээрээ үргэлжлүүлэхээр болжээ.

НҮБ–ын цөмийн хяналтын байцаагчдын мэдээлснээр, Иран Улс бөмбөгдөлтөд өртсөн уран баяжуулах байгууламжууд дээр тайлбарлагдаагүй үйл ажиллагаа явуулж байгаа нь АНУ–тай хийж буй цөмийн хөтөлбөрийн асуудлаарх хэлэлцээг хүндрүүлэх магадлалтай байна.

АНУ болон Ираны хооронд Ираны цөмийн хөтөлбөртэй холбоотойгоор хурцадмал байдал үргэлжилж, талууд харилцан сүрдүүлэг хийсээр байгаа юм. Ерөнхийлөгч Дональд Трамп Ойрхи Дорнод дахь АНУ–ын цэргийн хүчийг 2003 оноос хойших хамгийн их хэмжээнд нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь алтны үнийн өсөлтийг дэмжжээ.



Алтны үнийн ерөнхий хандлага

Алтны үнэ энэ оны эхнээс хойш 20 гаруй хувиар өсөөд байна. Нэгдүгээр сарын сүүлчийн түүхэн дээд түвшнээс огцом буурсны дараа дахин 5,000 ам.доллараас дээш тогтворжжээ. Мөн алт долоо дахь сар дараалан өсөлттэй хаагдсан нь 1973 оноос хойших хамгийн урт өсөлтийн цуваа болж байна.

Геополитикийн болон худалдааны хурцадмал байдал,

ам.долларын ханш сулрах хандлага мөн АНУ–ын Холбооны Нөөцийн Сан (Federal Reserve)–гийн хараат бус байдалд



тавигдаж буй эргэлзээ зэрэг нь алтны олон жилийн өсөлтийн трендийг улам дэмжиж байна.

Зах зээл тогтворжиж эхэлснээр хөрөнгө оруулагчид алтанд суурилсан биржээр арилжаалагддаг сангууд (ETF)–д дахин хөрөнгө оруулж эхэлжээ.

Зах зээлийн хаалтын ханш

- ◆ Спот алт: 1.5% өсөж, Нью–Йоркийн цагаар 15:52–д унц нь 5,263.39 ам.доллар
- ◆ Мөнгө: 6.2% өсөж, 93.80 ам.доллар
- ◆ Платинум болон палладий: хоёулаа өссөн
- ◆ Bloomberg Dollar Spot Index (ам.долларын индекс): 0.1%–иас бага хэмжээгээр буурсан


Эх сурвалж: Yahoo finance

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

S&P 500 / ^GSPC/

6,946.13 +56.06 (+0.81%)



Gold Apr 26 (GC=F)

5,378.90 +131.00 (+2.50%)




FTSE 100 / ^FTSE/

10,806.40 +125.82 (+1.18%)



NASDAQ Composite (^IXIC)

23,152.08 +288.40 (+1.26%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

 **1-110**
Авлигыг мэдээлэх утас